

# СОЁЛЫН ӨВИЙН

М Э Д Э Э , М Э Д Э Э Л Э Л

CULTURAL HERITAGE NEWS AND INFORMATION





СОЁЛЫН ӨВИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

“СОЁЛЫН ӨВИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ” сэтгүүл. 2014-2019/1 №8

**Сэтгүүлийг үүсгэн  
байгуулагч:**

Г.Энхбат .....

Соёлын өвийн үндэсний төвийн захирал, Доктор (Ph.D).

**Сэтгүүлийн зөвлөл:**

Г.Энхбат .....

Соёлын өвийн үндэсний төвийн захирал, Доктор (Ph.D).

О. Мэндсайхан .....

Соёлын өвийн үндэсний төвийн Захиргаа удирдлагын газрын дарга

Δ.Цэдмаа .....

“Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл” ТББ

Г.Гонгоржав .....

Удирдах зөвлөлийн гишүүн

Δ.Нарантуяа .....

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, соёл судлаач

Ш.Энхтуяа .....

Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн Бүртгэл судалгааны

Ц.Жаргалсайхан .....

газрын даргын үүрэг гүйцэтгэгч

Соёлын өвийн үндэсний төвийн Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч

Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны

газрын Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч

**Хэвлэлийн алба:**

П.Чинбат .....

Соёлын өвийн үндэсний төвийн систем хөгжүүлэлтийн инженер

## АГУУЛГА

### ӨМНӨТГӨЛ

Мэндчилгээ .....	4
Г. Энхбат	

### ХҮҮЛЬ ЭРХ ЗҮЙ

Соёлын өвийн үндэсний төвийн тухай .....	5
--	---

### СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тоолмого-2015.....	9
Г.Анхсанаа	

Дэлхийн өв-Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хадгалалт, хамгаалалтын асуудал .....	11
М.Цэцэнбилэг, Г.Бүрэнтөгс	

“Чулуун соёлын өв” Үндэсний хөтөлбөрийн танилцуулга .....	12
Г.Анхсанаа	

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрсдэлийн судалгаа .....	13
Г.Энхбат	

“Монгол Алтайн нурууны хадны зургийн хадгалалт, хамгаалалт” Хээрийн бүртгэл, судалгаа .....	14
Г.Анхсанаа	

Соёлын өвийн хамтын ажиллагаа- Дурсгалт уран барилгын гурван хэмжээст зураглал, бүртгэн баримтжуулалт .....	16
Д.Нарантуяа, Г.Бүрэнтөгс	

Соёлын биет өв - 3D бүртгэн баримтжуулалт .....	17
Б.Алтансүх, П.Чинбат	

Виртуал музей .....	19
Н.Энхбаяр	

Дэлхийн өвд бүртгэгдсэн Соёлын биет бус өвүүд .....	20
Ц.Жаргалсайхан	

Нүүдэлчин Монгол, Соёлын биет бус өвийн Их наадам-2018 .....	23
Ж.Насанжаргал	

Шүдэн уулын дурсгалыг авран хамгаалсан тухай .....	25
Г.Анхсанаа	

Соёлын биет бус өвийн Үндэсний хөтөлбөр батлаглаа .....	27
Ж.Насанжаргал	

Зүүн бүсийн Соёлын биет бус өвийн өвлөгдөл ба гээгдлийн судалгаа (Хэнтий, Дорнод аймаг) .....	28
Ж.Насанжаргал	

Соёлын биет бус өвийн эрсдэлийн судалгаа .....	30
А.Саруул	

### СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

“Хэрлэн барс”-ын Цамхагийн бэхжүүлэлт, сэргээн засварлалт .....	32
С.Чинзориг	

Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг хувилав .....	34
Г.Нямдорж, А.Мөнгөнцоож	

Үзүүр гялангийн хадны оршуулгын олдворын сэргээн засварлалт .....	36
Б.Мягмарсүрэн	

Шүдэн уулын олдворын сэргээн засварлалт .....	39
О.Оюунчимэг	

Археологийн органик эдлэлд терхалос сахарыг ашиглах нь .....	41
Д.Даваадарь	

<b>"Их бурхант"-ын сэргээн засварлалт .....</b>	<b>43</b>
Н.Жамбал	
<b>МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙ</b>	
<b>Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл ба мэдээллийн сан бүрдүүлэлт</b>	
(Соёлын төвийн ажилтнуудад зөвлөмж) .....	45
Д.Нарантуяа	
<b>Баримтат өвийн тухай .....</b>	<b>46</b>
Ш.Энхтуяа	
<b>Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт- мэргэжил, арга зүйн сургалтууд (2014-2018 он)</b>	<b>49</b>
Ц.Цолмон	
<b>"Монгол шоожны гайхамшиг" төслийг амжилттай хэрэгжүүлээ .....</b>	<b>52</b>
Б.Алтансүх	
<b>ТАНИН МЭДЭХҮЙ, МЭДЭЭЛЛИЙН БУЛАН</b>	
<b>Мартагдаж буй өв - Цахиур буу хийх технологи .....</b>	<b>53</b>
Ц.Жаргалсайхан	
<b>BRIEF IN ENGLISH</b>	
<b>М.Цэцэнбилэг .....</b>	<b>55</b>

## МЭНДЧИЛГЭЭ

“Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлийн шинэ дугаарыг хүлээн аваад байгаа уншигч Таны энэ өдрийн амар амгаланг эрье.

Манай Үндэсний төв энэхүү сэтгүүлийн анхны дугаарыг 2008 онд гаргаснаас хойш хэдийнээ 10 жил өнгөрөөд байна. Бид сэтгүүлээрээ дамжуулан Соёлын биет болон биет бус өвийн бүртгэн баримтжуулалт, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын хүрээнд хийгдсэн ажлууд, мэргэжил, арга зүй, танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэдэг билээ.

2014 оноос хойш сэтгүүл хэвлэгдээгүй хэсэг хугацаанд завсарласанд Та бүхнээс хүлцэл өчье. Энэ хугацаанд улс орны хэмжээнд соёлын өвийг хадгалж хамгаалах үйл ажиллагаа зогсолтгүй өргөжин тэлсээр томоохон өөрчлөлт, дэвшлүүд гарч олон арван ажлыг амжилттай хэрэгжүүлжээ. Соёлын өвийг хамгаалахтай холбоотой 2014-2018 онд хийгдсэн ажлуудыг тоймловол:

- Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014 онд шинэчилсэн найруулгаар батлагдав;
- 2015 онд улсын хэмжээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогыг анх удаа хийв;
- Бурхан Халдун уул ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн Жагсаалтад Монгол Улсаас соёлын ангиллаар бүртгэгдсэн 3 дахь өв болов;
- “Хэрлэн барс”-ын цамхаг, “Их бурхант” цогцолбор дурсгалыг сэргээн засварлах ажлыг гүйцэтгэж дуусгав;
- Монгол Улс ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн жагсаалтуудад бүртгүүлсэн өвийн тоо 14-т хүрэв;
- “Соёлын өвийн үндэсний төв” 2017 онд шинэчлэгдэн байгуулагдав;
- “Нүүдэлчин Монгол” Соёлын биет бус өвийн анхдугаар их наадмыг 2018 онд зохион байгуулав.

Эдгээр болон бусад мэдээг бид энэ удаагийн дугаарт хүргэж байна.



Соёлын өвийг дээдлэгч эрхэм уншигч Таны сэтгэл тунгалаг, мэлмийг гэгээн байж, өлмий бат орших болтугай.

Хүндэтгэсэн; Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, Доктор (Ph.D)

ХҮУЛЬ ЭРХ ЗҮЙ

## СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ТУХАЙ



### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 8 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

#### Дугаар 239 СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3, 46.6, Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1. Соёлын өвийн төвийн барилга байгууламж, эд хөрөнгө, тоног төхөөрөмжид түшиглэн Монгол Улсын соёлын өвийг бүртгэн мэдээлэх, авран хамгаалах чиг үүрэг бүхий "Соёлын өвийн үндэсний төв"-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулсугай.

2. Соёлын өвийн үндэсний төвийн талаар дараах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатарт даалгасугай:

2.1. Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж мөрдүүлэх;

2.2. музей, соёлын байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, хүний нөөцийг зохистой байршуулах замаар Соёлын өвийн үндэсний төвийн орон тоо, урсгал зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны батлагдсан төсвийн багцдаа багтаан хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх;

2.3. Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд соёлын биет өвийг сэргээн засварлах нэгжийг Соёлын өвийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцэд байгуулан ажиллуулах.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын сайд

Г.ЧУЛУУНБААТАР

## ХҮҮЛЬ ЭРХ ЗҮЙ



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХЛАН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ**

2017 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 1195

Улаанбаатар хот

Г Дүрэм, бүтэц шинэчлэн батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Соёлын өвийн үндэсний төв байгуулах тухай" 239 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Соёлын өвийн үндэсний төв"-ийн дүрмийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Соёлын өвийн үндэсний төвийн дүрмийг мөрдөж, батлагдсан бүтцийн дагуу ажлын байрыг оновчтой тогтоон баталгаажуулж ажиллахыг Үндэсний төвийн захирал /Г.Энхбат/-д даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны "Дүрэм батлах тухай" 125 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ц.ЦОГЗОЛМАА

03 1879

## ХҮУЛЬ ЭРХ ЗҮЙ



## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### **ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

#### **2.1.1. Соёлын өвийг бүртгэн мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:**

- соёлын өвийг эрэн сурвалжлах, таньж тогтоох, тодорхойлох;
- соёлын өвийг бүртгэх, баримтжуулж улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;
- хууль тогтоомжид заасны дагуу соёлын өвийн бүртгэл, тайлан мэдээг хүлээн авч, улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалах;
- соёлын өвийг таньж тогтоох, тодорхойлох, бүртгэх, баримтжуулах, хадгалах, сурталчлах талаар арга зүйн заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

- шатшатны бүртгэл, мэдээллийн санг арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

- соёлын өвийн мэдээллээр гэрэл зургийн цомог, сурталчилгааны хялбаршуулсан бүтээл гаргах, өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөл, холбогдох журмын дагуу зурагт хуудас, хэвлүүлэх, баримтат кино, медиа бүтээл хийж олон нийтэд сурталчлах;

- Улсын Их Хурал, Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагыг соёлын өвийн лавлагаа, мэдээллээр шуурхай хангах, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн соёлын өвийн лавлагаа мэдээллийг гаргаж өгөх;

- гадаад улс оронд хадгалагдаж байгаа монголын түүхэнд холбогдох соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх;

- соёлын өвийн ангилал, төрөл зүйлээр статистик мэдээлэл гаргах, тоо бүртгэл хөтлөх.

#### **2.1.2. Соёлын өвийг авран хамгаалах чиг үүргийн хүрээнд:**

- соёлын өвийг авран хамгаалах арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
- аж ахуйн нэгж, байгууллага, хувь иргэдээс палеонтологи,

археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийлгэх захиалгыг хүлээн авч, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг улсын хэмжээнд зохицуулах;

- аж ахуйн нэгж байгууллага, хувь иргэдийн аж ахуйн үйл ажиллагаа соёлын өвд нөлөөлөх байдлыг судалж дүгнэлт гаргах;

#### **2.1.3. Соёлын биет өвийг сэргээн засварлах чиг үүргийн хүрээнд:**

- соёлын биет өвийг бэхжүүлж, сэргээн засварлах арга зүйн судалгаа явуулах;

- түүх, соёлын дурсгалт зүйл, үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах;

- соёлын биет өвийг хадгалах талаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

- соёлын биет өвийг хамгаалах, сэргээн засварлах талаар санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх;

- п а л е о н т о л о г и , археологийн олдвор болон бусад дурсгалт зүйлийг шаардлага хангасан лаборатори, өрөө тасалгаанд түр хадгалах;

#### **2.1.4. Үндэсний төв нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3-т зааснаас бусад дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

- дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, даалгасан ажлыг шуурхай хэрэгжүүлж тайлagnах;

- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, хугацаат тайланг бэлтгэх;

- Дэлхийн өвд бүртгэгдсэн соёлын өвийн хамгааллын менежментийг хэрэгжүүлэх, хугацаат тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

- соёлын өвийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар бүх талын арга хэмжээг зохион байгуулах;

- соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, сурталчилгаар чиглэлээр олон улсын байгууллага, гадаадын байгууллагатай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

- Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өв болон өвлөн уламжлагчид гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах;

(БСШУС-ын сайдын 2017 оны А/295 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, Соёлын өвийн үндэсний төвийн дүрмээс)

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Г.Анхсанаа

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга

### ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО-2015

**С**оёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, ССАЖ-ын (хуучин нэрээр) сайдын 2014 оны А/63 тоот тушаалаар 2015 оны 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 01-нийг хүртэлх 6 сарын хугацаанд улс орон даяар түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг бүртгэх, тоолох ажил хийгдсэн билээ. Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ийн Археологи, Палеонтологийн хүрээлэн (тухайн үеийн нэрээр) шинжлэх ухааны байгууллагууд хамтран үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогыг хийх аймаг, орон нутгийн мэргэжилтэнгүүдийг мэдээлэл, арга зүйгээр ханганд ажиллаж тооллогыг богино хугацаанд амжилттай зохион байгуулав. Үзлэг, тооллогын ажилд орчин үеийн шинэ технологи хэрэглэн нэвтрүүлсний дүна:

- Манай улсад мөрдөгдөж байгаа UTM тусгагийг хэрэглэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын



Бүртгэн баримтжуулалтын явц

- газар зүйн байршлыг тогтоон,
- Тоологдсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар, дурсгал нэг бурийн засаг захиргааны байршил, хамаарах төрөл зүйлийн ангиалал, тоо ширхгийг илэрхийлсэн бүтэц бүхий улсын бүртгэлийн дугаартай болгож,
- Тусгайлан боловсруулсан үл хөдлөх дурсгалыг бүртгэх цахим бүртгэлийн програм (RICH буюу Registration of Immovable Cultural Heritage 3.0)-ийн дагуу бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бий болсон байна.

Энэхүү 2015 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллоогоор:

- 21 аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийт 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэсэн. Нийт тоологдсон дурсгалт газар, дурсгалуудаас 3387 дурсгалт газрын 44977 дурсгал буюу 52.2% нь үзлэг тооллогын хүрээнд шинээр бүртгэгдсэн байна.

- Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д орсон 452 дурсгалт газрын 98% буюу 443 нь үзлэг, тооллогод хамрагдсан,

- Засгийн газрын шийдвэрээр 1997-2013 онуудад хамгаалалтын бүс тогтоогдсон аймаг, нийслэлийн 35 дурсгалт газар үзлэг, тооллогод бүрэн хамрагдсан,

- Засаг захиргааны харьяаллын нэр маргаантай ташаарсан, солигдсон зэрэг 61 дурсгалт газрын эзэмшлийн нэрийг залруулсан, сум, орон нутагт 4516 дурсгалыг гэрээгээр хамгаалан ажиллаж байгаа зэрэг дүн мэдээ гарсан болно.

Үзлэг тооллоогоор дурсгалын хадгалалт, хамгаалалтын өнөөгийн

нөхцөл байдал, эвдрэл, гэмтлийн талаарх мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийлээ. Тооллогод хамрагдсан нийт дурсгалын 12,7 % буюу 11007 дурсгал хүний нөлөөллөөр гэмтсэн бөгөөд үүнээс; тоносон 16%, сүйтгэсэн 31%, будаж балласан 10%, хугалсан 9,7%, сийлсэн 2,5%, зөөгдсөн 3,3%, алга болсон 3,2%, тос, сүүний бохирдолтой 8,8%, буруу зассан 2,4%, хадаг, бөс даавуу ороосон, уясан 4,8%, дэд бүтшийн аюулд өртсөн 2%, аж ахуйн үйл ажиллагаанд өртсөн 4,6% тус тус эзэлж байгаа нь байгалийн нөлөөлөл гэхээсээ илүү үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон хүний хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэлтэй эвдрэл гэмтлүүд голлож байна.


Үзлэг тооллоогоор цуглагдсан бүртгэл, мэдээлүүд нь цаашдаа үл хөдлөх дурсгалуудын хадгалалт, хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэхэд үндсэн бааз мэдээлэл болон ашиглагдах юм.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2015 онд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогод хамрагдсан нийт дурсгалт газар, дурсгалын тоо

Аймгийн нэр	Чулуун газар	Зэвсгийн дурсгалт	Хадны дурсгал		Бүлүүн бичгийн дурсгал		Тахил тайлтын байгууламж		Барилга, архитектурын дурсгал		Хөшөө дурсгал		Үйдвэрлэлийн ул мөр хамгасан дурсгалт газар	Палеонтологийн газар	Дурсгалт газар	Нийт дурсгалт газар	Нийт дурсгал
			ΔГ	Δ	ΔГ	Δ	ΔГ	Δ	ΔГ	Δ	ΔГ	Δ	ΔГ	Δ			
Архангай		37	23	92	2674	32	65	42	125	111	142					314	3029
Баян-Өлгий	36	26	29	432	4018	71	443			259	624					824	5150
Баянхонгор	7	48	5320	99	1767	74	172	50	115	79	162	3		2	362	7548	
Булган	2	139	165	205	2645	15	16	52	52	99	177	1			513	3058	
ГОВЬ-АЛАТАЙ	3	90	105	821	5131	61	80	42	45	119	261	1	3	1134	5629		
ГОВЬСҮМБЭР		1	1	33	284	8	8	5	5	8	8				55	306	
ДАРХАН-ҮҮЛ		5	5	20	318	2	3	23	23	3	5				53	354	
ДОРНОГОВЬ	1	35	46	166	750	99	111	96	1597	13	18	3	18	431	2544		
ДОРНОД	10	4	7	108	2020	18	103	92	117	17	40	2			251	2299	
ДУНДГОВЬ	2	36	37	151	1392	63	65	44	44	6	7	1	3	306	1551		
ЗАВХАН		93	101	314	6995	113	616	34	36	175	1186				729	8934	
ОРХОН				28	343			5		6	11				39	354	
ӨВӨРХАНГАЙ	4	50	118	314	6165	70	147	57	60	60	114	7	4	566	6619		
ӨМНӨГОВЬ	1	51	51	43	2148	24	24	62	62	13	13	3	16	213	2318		
СҮХБААТАР	27	21	20	97	1157	42	42	50	63	39	97	1			277	1407	
СЭЛЭНГЭ	4	20	44	240	2861	3	3	25	35	47	52	4		343	3003		
ТӨВ		21	178	227	2895	43	1397	71	106	26	92	1			389	4669	
ҮВС		79	86	162	1573	17	17	4	6	202	395		1	464	2077		
ХОВД		92	307	305	5947	61	237	35	35	88	484	3	5	589	7018		
ХӨВСГӨЛ	2	72	91	485	10721	23	34	25	24	91	207	2		700	11081		
ХЭНТИЙ	32	58	59	551	5776	113	580	124	148	104	132	3		985	6730		
ҮЛАНБААТАР		3	3	60	347	5	4	146	122	3	3			217	479		
<b>НИЙТ ДУРСГАЛТ ГАЗАР</b>		<b>981</b>		<b>4953</b>		<b>957</b>		<b>1084</b>		<b>1562</b>					<b>9537</b>		
<b>НИЙТ ДУРСГАЛ</b>	<b>131</b>		<b>6796</b>		<b>67927</b>		<b>4167</b>		<b>2820</b>		<b>4230</b>	<b>35</b>	<b>51</b>			<b>86157</b>	

СОЁЛЫН ӨВИЙН УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭГДСЭН 9537 ДУРСГАЛТ ГАЗРЫН 86157 ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЭЗЛЭХ ХҮВЬ /төрөл зүйлийн ангилаар/



## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**М.Цэшэнбийлэг**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга

**Г.Бүрэнтөгс**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл, мэдээллийн санч

2015 оны 6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 8-ны хооронд ХБНГУ-ын Бонн хотноо болсон ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны 39 дүгээр чуулганаар Монгол Улсын нэр дэвшүүлсэн "Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг" номинац Дэлхийн өвийн жагсаалтад соёлын ангиллаар бүртгэгдлээ.

"Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг"-ийг Дэлхийн өвийн Жагсаалтад бүртгэх 10 шалгуурын соёлын 4, 6 дугаар шалгуураар Дэлхийн өвийн хорооны Зөвлөх байгууллага Хөшөө дурсгал, дурсгалт газруудын олон улсын зөвлөл (ICOMOS) Бурхан Халдун уул бол Чингис хааны намтар түүхтэй нягт холбоотой Дэлхийн өвийн Конвенцийн Дэлхийн нийтийн Хосгүй гайхамшигт үнэ цэнэт болохыг дүгнэн тодорхойлжээ.

Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Батширээт, Төв аймгийн Мөнгөнморьт сумын газар нутгийг хамарсан 441507.7 га хамгаалалтын бус, 711332 га орчны бус бүхий нутаг дэвсгэрийг эзлэдэг. Энэхүү газар нутагт палеолит, неолитийн үеэс олдвор дурсгалуудаас эхлэн монголын эртний овог аймаг улсуудын сүлд тамга тэмдэг бүхий археологийн дурсгалт цогцолбор "Рашаан хад", Чингис хааны "Морины уяа" хэмээн домоглодог эртний хот туйр "Өглөгчийн хэрэм", шашны анхдугаар тэргүүн-Өндөр гэгээн Занабазарын бүтээлийн сүм гэх "Сарьдагийн хийд", мөн "Гүнжийн сүм", "Бэрээвэн хийд" зэрэг түүхэн дурсгалт газрууд бий.

Нэн эртний үеэс эхлэн нүүдэлчдийн амьдралын нэгэн төв болж байсан энэхүү газар нутаг нь соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт

## ДЭЛХИЙН ӨВ - БУРХАН ХАЛДУН УУЛ, ТҮҮНИЙГ ХҮРЭЭЛСЭН ТАХИЛГАТ ГАЗАР НУТГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН АСУУДАЛ



Бурхан Халдун уул

ахуйтайгаа харилцан шүтэлсэн соёлын орон зай бүхий соёлын өвийн дурсгалт газар нутгийн нэг юм. Өдгөө энэ бус нутагт Монголын урианхай, буриад, халх ястангууд нүүдлийн аж ахуйгаа эрхлэн, ахуй соёл, зан заншлаа өвлөн уламжилсаар ирсэн билээ.

Эртний түүхтэй төрийн тахилгат, дархан цаазат, үндэсний бахархалт хайрхан Бурхан Халдун уул, түүний тахилгат газар нутгийг хамгаалан хөгжүүлэхэд олон нийтэд таницуулах, сурталчлах, соёлын өвийн мэдлэг олгох, дотоод, гадаадын олон жуулчид, аялагчдын бус маршуутыг тогтоох, бус нутгийн хүрээнд соёлын биет болон биет бус өв, түүний дотор "Эх хэл болон аман уламжлал", "Уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам", "Байгаль болон сав ертөнцийн тухай уламжлалт мэдлэг, арга, ухаан" зэрэг мэдээллийн сүлжээг бий болгох зэрэг байгаль, нийгэм, эдийн засгийн олон талт болого чиглэлээр, бус нутгийн эртний нүүдэлчдийн соёл, аж ахуй, оюун санааны бүтээл, зан үйл, ёс заншил

зэргийг нэхэн тодруулахад үнэтэй хувь нэмэр оруулахуйц олон чухал баримт мэдээллийн цогц санг бий болгоход үр дүнгээ өгөх болно.

Дэлхийн өв - Бурхан Халдун уул, түүний тахилгат газар нутгийн хадгалалт, хамгаалалт менежментийн хүрээнд:

- Бус нутгийн хүрээн дэх соёлын өвүүдийг тодорхойлж, нүүдлийн соёл иргэншлийн төрхийг хадгалсан соёлын бус бий болгох бодлого боловсруулж, Монгол Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын маршрутын нэгдсэн бодлоготой уялдуулах,

- Дурсгалт газруудыг нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, байгалийн гамшигаас урьдчилан төлөвлөгөө боловсруулах,

- Тухайн дурсгалт газрууд оршиж байгаа бус нутагт эрсдэлийн болон чанарын судалгаа хийж, тэдгээрт нөлөөлж байгаа байгалийн болон нийгмийн хүчин зүйлсийг олж тогтоох, бууруулах арга хэмжээ авах зэрэг олон талын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Г.Анхсаная**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга

### “ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

**М**анай улсын нутаг дэвсгэрт Морших түүх, соёлын үл хөдлөх дурсгал түүн дотроо археологийн дурсгалын ихэнх хувийг чулуун соёлын дурсгал эзлэх бөгөөд тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын асуудал сүүлийн жилүүдэд тулгамдаад байгаа билээ. Тиймээс дээрх төрлийн дурсгалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас “Чулуун Соёлын Өв” үндэсний хөтөлбөр боловсруулсаныг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор батлан, 2019-2024 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

Санхүү, хүний нөөц, техник технологийн боломжид тулгуурлан тодорхой дурсгалуудыг сонгон хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан арга зүйн дагуу гүйцэтгэх, чулуун дурсгалыг хамгаалах хэтийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, аялал жуулчлалтай уялдуулан хөгжүүлэх, гадаад, дотоодод сурталчлах зэрэг цогц

арга хэмжээ хэрэгжүүлэх замаар чулуун соёлын өвийг хамгаалахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн үндсэн зорилтыг уг хөтөлбөрт дэвшүүлсэн байна.

2015 онд улсын хэмжээнд явуулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын дүн мэдээгээр манай улсын нутаг дэвсгэр дээр 4230 хөшөө чулуу, 6796 хадны зураг, бичгийн дурсгал бүртгэгдсэнд ихэнх нь байгаль, нийгмийн хүчин зүйлийн нөлөөгөөр их, бага хэмжээгээр эvdэрч гэмтсэн байна. Ялангуяа цаг уурын өөрчлөлт, уул уурхай, зам харилцаа зэрэг шинэ бүтээн байгуулалт, аялал жуулчлал, шашин шүтлэгийн нөлөөгөөр чулуун соёлын өвд хохирол учрах явдал түгээмэл тохиолдоор байна.


Чулуун соёлын өвийг сэргээн засварлах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, олон нийтэд сурталчлах чиглэлийн 70 орчим ажлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусlamж, хөрөнгө оруулалт, иргэд, аж ахуйн нэгжийн хандив зэрэг санхүүгийн



Говь-Алтай аймаг. Тонхил сум.  
Шатадын бэлчирийн хүн чулуу

эх үүсвэрээр гүйцэтгэхээр уг хөтөлбөрт тусгагдсан бөгөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ын Түүх, археологийн хүрээлэн зэрэг мэргэжлийн байгууллага, орон нутгийн захиргаа болон холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлэхээр заажээ.

Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол орны хэмжээнд чулуун дурсгалын хадгалалт, хамгаалалт судалгааны арга зүйг боловсруулах, үйл ажиллагаа бодитоор сайжрахад эерэгээр нөлөөлөх, цаашлаад энэ төрлийн дурсгал дэлхийн өвд бүртгэгдэх, салбар хоорондын хамтын ажиллагааны хөгжилд олон талын ач холбогдолтой юм.



Өмнөговь аймаг. Ноён сум. Хоргын эхний хадны зураг.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Г.Энхбат

Соёлын өвийн үндэсний төвийн захирал, Доктор (Ph.D)

### ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА

**С**оёлын өвийн хадгалалт хамгаалалтын үндсэн асуудал бол өвийн үнэ цэнийг алдагдуулахгүйгээр урт удаан хугацаанд хадгалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах явдал юм. Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг оновчтой явуулахын тулд соёлын өвийн төрөл тус бүр дээр эрсдэлийн үнэлгээг хийх шаардлага зүй ёсоор тулгардаг. Өдгөө олон улсад соёлын өвийн эрсдэлийн судалгааг хийх олон арга зүйт боловсруулж, туршсаар байна.

Манай орны хувьд өргөн уудам газар нутагтай, хүн ам цөөн, түүх, соёлын дурсгал нь таруу байрласан, дурсгалын хадгалалт хамгаалалтын хүртээмж мүү байдаг учраас хадгалалт хамгаалалтын оновчтой бодлого, үр дүнтэй үл ажиллагааг авч хэрэгжүүлэхийн тулд эрсдэлийн үнэлгээг хийх шаардлага тулгарч байна.

Тиймээс; Соёлын өвийн үндэсний төвөөс Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрсдэлийн газрын зураг болон "эрсдэл ихтэй" газарт байгаа үл хөдлөх дурсгалыг олж тогтоо арга зүйт боловсруулах судалгааг 2015-2017 оны хооронд хийж гүйцэтгэв. Тус ажлын хүрээнд 4 үндсэн зорилтыг дэвшүүлсэн бөгөөд үнда:

1. Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын орон зайн мэдээлэл бүхий газарзүйн мэдээллийн системд сууринсан мэдээллийн сан бий болгох,
2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтад сөргөөр нөлөөлж буй байгаль, нийгмийн хүчин зүйлсийг олж тогтоох, тэдгээрийн эрсдэлийн төвшинг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох,
3. Монгол орны нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан үл хөдлөх дурсгалын эрсдэлийн газрын зураг боловсруулах,
4. Эрсдэлийн газрын зургийг

үндэслэн Монгол орны хэмжээнд байгаа эрсдэл ихтэй (нэн түрүүнд хамгаалах шаардлагатай) дурсгалуудыг олж тогтоо зэрэг зорилтууд оров.

Дэвшүүлсэн зорилтуудын дагуу дараах үр дүнд хүрлээ.

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, мэдээллийн санд буй 24431 дурсгалаас судалгааны үр дүнд эрсдэлийн үнэлгээгээр Их, Дунд, Бага, Маш бага эрсдэлтэй газар нутагт буй дурсгалын статистик тоон дүн дараах байдлаар илрхийлэгдэн гарлаа. Үнда:
- Монгол нутаг дахь үл хөдлөх дурсгалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн эрсдэлийн үнэлгээгээр ИХ ЭРСДЭЛ учруулах хүчин зүйлд, ашигт

Эрсдэлийн зэрэг	Чулуун эзвэлж, чимлээрээмин үл мөр хадгасан дурсгалт газар	Хадны зураг, бичгийн дурсгал	Бүүх оршууллын дурсгал	Сүм хийд, уран барилтын дурсгал	Эртний хот, сум хийдийн түүрь, багас	Хөшөө дурсгал (такхи тайлтын байгууламж)	Палеонтологийн дурсгалт газар	Нийт дурсгалын тоо
Их эрсдэлтэй	11 (3,0 %)	17 (1,3%)	91 (0,6%)	28 (3,7%)	12 (3,0%)	28 (0,5%)	0	187 (0,8%)
Дунд эрсдэлтэй	58 (14,0 %)	99 (7,3%)	2361 (14,3%)	108 (13,9%)	45 (11,2%)	371 (7,4%)	1 (2,3%)	3043 (12,5%)
Бага эрсдэлтэй	146 (36,0%)	300 (22,2%)	7377 (45,0%)	216 (27,8%)	125 (31,0%)	1182 (23,5%)	14 (31,7%)	9360 (38,2%)
Маш бага эрсдэлтэй	189 (47,0%)	934 (69,2%)	6592 (40,1%)	423 (54,6%)	221 (54,8%)	3453 (68,6%)	29 (66,0%)	11841 (48,5%)
НИЙТ	404	1350	16421	775	403	5034	44	24431

малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, авто болон төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, ДҮНД ЭРСДЭЛ учруулах хүчин зүйлд, ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, БАГА ЭРСДЭЛД орон нутгийн замтай ойр үед эрсдэл учруулах тохиолдлууд ажиглагдаж байна.

- Үл хөдлөх дурсгалын 7 төрөл тус бүрийн төрөлжсөн эрсдэлийн зургуудыг давхцуулан Эрсдэлийн нэгдсэн зургийг боловсруулахад дараах үр дүн гарав. Үнда:
  - Дурсгалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн эрсдэлийн нэгдсэн үнэлгээнээс тооцоолоход, Монгол Улсын нийт 1574533 км<sup>2</sup> газар нутгийн хэмжээнд **их эрсдэл** учруулах 8942 км<sup>2</sup> талбай буюу газар нутгийн 0.56%, **дунд эрсдэл** учруулах 112195 км<sup>2</sup> талбай буюу газар нутгийн 7.1%, **бага эрсдэл** учруулах 489430 км<sup>2</sup> талбай буюу газар нутгийн 31% -ийг эзэлж байгаа бол, **маш бага эрсдэлтэй** газар нутаг нь 963966 км<sup>2</sup> талбай буюу газар нутгийн 61.2% байна.

Судалгааны ажлын үр дүнг "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах", "Соёлын өвийн эрсдэлийн атлас" ном болгон хэвлэн нийтэлж, соёлын өвийн шат, шатны шийдвэр гаргагчид, бүртгэл, мэдээллийн сангийн ажилтнууд, соёлын өвийг хамгаалагчидад үнэ төлбөргүй түгээн олон нийтэд хүргэлээ.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Г.Анхсаная**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга

### **“МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ ХАДНЫ ЗУРГИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ” ХЭЭРИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГАА**

**М**онгол Алтайн нурууны хадны зургийн дурсгалт газар нь соёлын ангиллаар Дэлхийн өв (2011 он)-д бүртгэгдсэн дурсгалт газар бөгөөд Соёлын өвийг хамгаалах хуулийн 42.3-т Соёлын өвийн дурсгалт газарт үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газар хамаарна хэмээн заасан байдаг.


Соёлын өвийн үндэсний төв 2015 оноос эхлэн Монгол Алтайн нурууны хадны зургийн хадгалалт, хамгаалалтыг сурталчилгаагаар дамжуулан сайжруулах, орон нутгийн иргэдийн соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх, олон нийтэд Монгол Алтайн хадны зургийг хүртээмжтэй байдаар цахим орчинд сурталчлахаар Баян-Өлгий аймгийн музейтэй хамтарсан хээрийн судалгааг хоёр дахь жилээ хийлээ.

2017 онд Улаан хус сумын нутаг Цагаан салаа, Бага ойгор, Цэнгэл сумын нутаг Шивээт хайрхан, Араг толгой гэсэн маршрутаар 1000 орчим км аялж нийт дээрх гурван дурсгалт газарт 36 солбицол тогтоож 33 панорам (Цагаан салаа/Бага ойгор 23,

Шивээт хайрхан 5, Араг толгой 5), Засгийн газрын тогтооолоор улс, аймгийн хамгаалалтын жагсаалтад бүртгэгдсэн Хар Ямаат, Даян баатрын хөшөө, Битүү, Харгайтын хүн чулуу зэрэг дурсгалуудыг гэрэл зураг, фотограметр хийн баримтжуулав.

2018 оны хээрийн судалгаа нь тухайн бүс нутгийн улс, аймгийн хамгаалалтын жагсаалт дахь дурсгалуудын бүртгэл, баримтжуулалтыг сайжруулах, мэдээллийн санг баяжуулах, хадны зурагт сөргөөр нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг судлах, хадны зураг дээр сийлсэн хэсгийг нөхөх, түүнд тохирох материал, аргачлалыг турших, зарим ач холбогдол бүхий хадны зургаас дардас авахад чиглэгдэв.

Сүүлийн жилүүдэд Дэлхийн өвд бүртгэгдсэн энэ бүс нутгийн хадны зургийн дурсгалт газруудад нутгийн иргэд нэр ус, элдэв зураг зэргийг сийлэх явдал баагүй гарч байна. Тухайлбал, Шивээт хайрхан, Цагаан салаа/Бага ойгор орчимд малчдын хаваржаа, намаржаа, өвөлжөөний нийт 35 орчим газар байна. Эдгээрийн байршилыг хадны



Шивээт хайрханы хадны зураг.

зургийн дурсгалтай давхцуулан газрын зурагт буулгахад ихэнх вандализмд өртсөн хадны зургууд айлын өвөлжөө, хаваржаа, намаржааны ойр орчимд байгаа нь ажиглагдаа. Хадны зурагт сөргөөр нөлөөлж байгаа хүний хүчин зүйлс нь ихэвчлэн нутгийн малчдаас үзүүлэлтэй байгаа нь харагдаж байна. Үүнд, ихэвчлэн хадны зураг дээр өөрсдийн нэр, он сар, элдэв зураг зурж сараачих, хадны зурагтай хадыг малын болон өвсний хашаа, хороо, байшин суушандaa зөвж ашиглах зэрэг сөрөг үйлдлүүд хийж байна.

Тухайлбал, Шивээт хайрхны хадны бүлэг зургууд бүхий хавтан чулууны зүүн урд хэсэгт байх томоохон хэмжээний морины дүрслэл бүхий зургийн доод хэсэгт 20 см урт 3 см өргөнтэй, 3-4 мм өргөн зураас гаргаж 1-3 мм орчим гүн “Секу-айну” гэж сийлж бичсэн байна. Дурсгалын үнэ цэнийг алдагдуулсэн энэхүү бичээсийг арилган бүдгэрүүлэх сэргээн засварлах туршилт хийв. Дурсгалын гадаргууг сайтар цэвэрлэж хатаасны дараа эпокси



Шивээт хайрханы хадны зурганд нөхөлт хийж буй байдал.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

цавуу (55-60%)-нд чулууны нунтаг үйрмэг (35-40%) болон Булган сумаас олборлож байсан цэвэр байгалийн гаралтай хуурай пигмент (5%)-ийг өнгө будгийг ойртуулах, дөхүүлэх зорилгоор хольж зууран, ухаж сийлсэн бичээсийг шавж, нөхөлт хийж сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үг дурсгал 2450 м өндөрт, байгаль цаг уурын онцгой ширүүн бүсэд байрлаж байгаа нь цаашид энэ төрлийн чулуун дурсгалын сэргээн засварлалтын ажлын үр дүнг шалгах, тогтооход чухал юм.

Мөн ажлын хүрээнд Хар ямаатын голын хүн чулуун хөшөөний хагарч салсан хэсгүүдэд механик хуурай цэвэрлэгээ хийж, сэргээн засварлалтын технологийн дагуу эвлүүлэн нааж бэхжүүлэв.

Арал толгойн хадны зураг нь он цагийн хувьд эрт үед холбогдох бөгөөд ихэнх хадны зургууд нэлээд бүдгэрсэн байдалтай, хаг, хөвд бараг бүх зураг дээр ургажээ. Хилийн цэргийн застав дэргэд нь байрлах тул Арал толгойн хадны зургууд хүний нөлөөлөлд харьцангуй бага өртсөн байна.

2019 онд Соёлын өвийн ҮНБМСанд цуглуулсан хэрэглэгдэхүүн болон хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг цахим болон хэвлэмэл байдлаар орон нутгийн иргэдээд сурталчлах ажлыг ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссоос Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан "Дэлхийн өвийн хөдөлгөөнт сургалт"-ын үеэр хийж, [www.mongolaltai.mongoluv.mn](http://www.mongolaltai.mongoluv.mn) цахим хуудас, Монгол, казах хэлээр гарсан Дэлхийн өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор (хадгалалт хамгаалалтын гарын авлагы) хэвлэмэл материалыг орон нутгийн удирдлагууд, холбогдох байгууллагууд болох аймгийн музей, Алтайн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөв.



СОЁЛЫН ӨВИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВ



ҮЛТТЫК МӨДӨНИ  
МУРА ОРТАЛЫЫ

ДЭЛХИЙН ӨВ-МОНГОЛ АЛТАЙН  
НУРУУНЫ ХАДНЫ ЗУРГИЙН  
ЦОГЦОЛБОР  
(ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ГАРЫН АВЛАГА)

БҮКІЛӘЛЕМДІК МУРА – МОНГОЛ  
АЛТАЙ ЖОТАЛАРЫНДАҒЫ  
ЖАРТАС СҮРЕТТЕРИНІҢ КЕШЕНІ  
(САҚТАЛ ҚОРҒАУҒА БАЙЛАНЫСТЫ КИТАПША)

Хадгалалт хамгаалалтын гарын авлага (нүүр)



Баян-Өлгий аймгийн ЗДТГазарт зохион байгуулсан сургалт.



2019 оны хээрийн судалгааны баг.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### **Д.Нарантуяа**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

### **Г.Бүрэнтөгс**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариусан бүртгэл, мэдээллийн санч

## **СОЁЛЫН ӨВИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ДУРСГАЛТ УРАН БАРИЛГЫН ГУРВАН ХЭМЖЭЭСТ ЗУРАГЛАЛ, БҮРТГЭЛ БАРИМТЖУУЛАЛТ**

**М**онгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Соёлын өвийн үндэсний төв, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн хамтран “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох сүм хийд, уран барилга,

Үнстийн хийд (Дундговь аймгийн Эрдэнэдалай сум), 2017 онд Заянх хүрээний Цогчин дуган (Архангай аймгийн Цэцэрлэг хот), 2018 онд Чойжин ламын сүм музейн Гол сүм (Улаанбаатар хот) зэрэг улс, аймгийн хамгаалалтад байх эртний уран барилга, архитектурын 6



Архангай аймгийн Өлзийт сумын нутагт орших Өлдөл бэйсийн хүрээний Цогчин дуган, Жүд дацангийн 3D модель. (2015-2016 он)


архитектурын дурсгалыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх” тухай Хамтын ажиллагааны Санамж бичигийг 2015 онд байгуулан амжилттай ажиллаж байна.

Хамтын ажиллагааны Санамж бичиг нь 2015-2020 он хүртэл үргэлжлэх ба энэхугацаанд Засгийн газрын шийдвэрээр улсын болон аймаг, нийслэлийн хамгаалалтын жагсаалтад бүртгэгдсэн эртний түүхт уран барилга архитектурын дурсгалын 3D хэмжилт судалгаа, бүртгэл баримтжуулалтыг хийж, мэргэжилтэн бэлтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх зорилготой юм.

Төслийн хүрээнд 2015 онд Өлдөл бэйсийн хүрээний Цогчин дуган, Жүд дацан (Архангай аймгийн Өлзийт сум), 2016 онд мөн Өлдөл бэйсийн хүрээний Шамын Аасар,

объект дурсгалуудад уламжлалт гар хэмжилт, техникийн дэвшилтэй төхөөрөмж 3D сканер ашиглан судалгаа хийж, ажлын тайллангуудыг эмхэтгэн хэвлүүлээ.

Б а р и л г а



Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших Үнстийн хийдийн Цогчин дуганы 3D модель. (2016 он)

архитектурын зураглалыг 3D лазер хэмжилтийн багаж ашиглан тухайн объектуудын хана түүргэ, багана, хаалга, цонх, шал зэрэг барилгын хийц бүтээцийн дээд, доод давхар, дотор, гадна талын хэмжилтүүдийг хийсэн ба 3D лазераар хэмжих боломжгүй хэсгүүдэд шугам, метр ашиглан уламжлалт аргаар хэмжилт хийсэн. Гар хэмжилтийг 3D скан дата-г нөхвөрлөх шаардлагатай хэсэгт голчлон явуулав. Дээврийн дээд хэсэг сканердахад агаарын дрон ашиглан зураг авч, дээд давхрын хийц бүтээцийн хэмжилт судалгааг гар хэмжилт, фото зургийн хосолмол аргаар нөхвөрлөх хэмжилтүүд хийгдсэн байна.

Хамтарсан судалгааны баг хэмжилт судалгааны ажлын үеэр монголын талын мэргэжилтэнгүүдэд 3D хэмжилт, агаарын дрон ашиглах арга технологи зааж, тус төвийн 2 мэргэжилтэн БНСУ-д урт, богино хугацаагаар дадлагажуулах, мэргэшүүлэх сургалтад хамрагдээ.

Уран барилга архитектурын соёлын өвийг баримтжуулах ажил нь архитектурын дурсгалын анхны хэлбэр төрхийг баримтжуулан, тухайн судалгааны объект болох дурсгалт барилгын түүхэн архитектурын хийц, бүтээцийг хадгалж хамгаалах үндсэн

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

аргын нэг бөгөөд цаашид энэхүү 3D баримтжуулалтын ажлыг археологийн малтлага судалгаатай хавсарсан байдааар явуулбал тухайн хот суурины төлөвлөлт, барилга-архитектурын бүтэц, зохион байгуулалтыг талаарх мэдээллийг бүрэн баримтжуулах боломжтой болох юм.

Судалгааны ажлын цуврал тайланг монгол, солонгос, англи хэлээр хэвлүүлж, мэргэжлийн байгууллага, холбогдох их дээд сургууль, улсын болон 21 аймгийн номын санггуудад үнэ төлбөргүй тараан, олон нийтэд хүргэв. Тайланд монголын сүм хийдийн барилга архитектурын үүсэл хөгжил, тухайн сүм хийдийн шашны түүхэн тойм судалгаа, тухайн хамрагдсан объектуудын 3D болон гар хэмжилтийн зураг, гэрэл зураг зэргийг бүрэн тусгажээ.



Архангай аймгийн Эрдэнэбулаг сумын нутагт орших Заяны хүрээний Цогчин дуганы 3D модель. (2016 он)

Сүм хийдийн барилга архитектурын 3-н хэмжээст баримтжуулалт нь нурж устах аюулд орсон эртний хот суурин, сүм хийдийг цахим архив үүсгэн

хадгалах, хамгаалах ажлын эхлэл ба цаашид тухайн объектийн сэргээн засварлалтын ажилд ашиглах боломжтой.

**Б.Алтансүх**

"Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл" ТББ-ын тэргүүн

**П.Чинбат**

Соёлын өвийн үндэсний төв, Мэдээлэл технологийн газрын мэргэжилтэн

Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь соёлын өвийг баримтжуулан, улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бурдгүүэх явдал юм. Энэ чиг үүргийнхээ дагуу анх байгуулагдсан цагаас эхлэн соёлын өвийг баримтжуулах ажлыг чанартай, үр дүнтэй хийх тал дээр онцгой анхаарч, шинэ техник, технологи нэвтрүүлэх болон хүний нөөцийг чадавхижуулах ажлыг тасралтгүй хийсээр ирсэн юм.

Засгийн газрын 2005 оны 244 дүгээр тогтоолоор хэрэгжүүлсэн "Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр"-ийн хүрээнд улс, аймгийн нийт 35 музейд "Хагас мэргэжлийн" ангиллын шинэ дижитал гэрэл зурийн аппарат, бүртгэлийн програм бүхий компьютер зэргийг хүлээлгэн өгсөн нь тухайн үедээ музейн салбарт хийгдсэн

## СОЁЛЫН БИЕТ ӨВ- 3D БҮРТГЭН БАРИМТЖУУЛАЛТ

техникийн томоохон хөрөнгө оруулалт байлаа. Энэ хөтөлбөрийн үр дүнд музейн үзмэрийг гэрэл зургаар баримтжуулахад дэвшил гарч соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийн баяжилт нэг шатаар урагшилсан гэж хэлж болно.

Техник технологийн хөгжихийн хэрээр соёлын өвийн баримтжуулалтыг илүү үр дүнтэй хийх арга, хэрэгслүүд шинээр бий болсоор байгаагийн нэгнээ 3D лазер сканнер юм. 3D лазер сканнер нь секундад хэдэн зуун мянган цэгийг өндөр нарийвчлалтайгаар хэмжиж компьютерт хадгалах хүчин чадалтай байдаг бөгөөд өдгөө дэлхий дахинд гэмт хэргийн баримтжуулалт, авто болон нисэх онгоцны үйлдвэрлэл, уул уурхай

зэрэг олон салбарт үр дүнтэй ашиглагдаж байгаагийн нэг нь соёлын өвийг хамгаалах салбар юм.

Соёлын өвийн үндэсний төв нь бүртгэн баримтжуулалтыг илүү үр дүнтэй хийх зорилгоор 3D лазер сканнер ашиглан соёлын биет өвийг баримтжуулах ажлыг анх 2008 оноос хийж эхэлсэн. Музейн үзмэрээс Г.Занабазарын мутрын болон түүний сургууль хийцийн түүх, соёлын "Хосгүй үнэт" зэрэглэлд орсон цутгуур бурхад, үл хөдлөх дурсгалаас Их Монголын үеийн (XIII-XV зуун) хүн чулуун хөшөөнүүдийг нэн түрүүнэд баримтжуулж, мэдээллийн сан бурдгүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Соёлын өвийн үндэсний төв 2014-2018 оны хоорона дараах 11 байгууллагын 41 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг 3D-ээр бүртгэн баримтжуулсан. (Хүснэгт1)**

Nº	Байгууллагын нэр	Үзмэрийн нэр	Тоо ширхэг	Он	3D scanner
1	Богд хааны ордон музей	Цутгуур бурхан	3	2015	VIVID 9i
2	Монголын үндэсний музей	Хүрэл тогоо	3	2015	VIVID 9i
3	ШУА-ын Түүх, археологийн хүрээлэн	Язгуурын таван бурхан (Сарьдагийн хийд)	6	2015	VIVID 9i
4	Дүрслэх урлагийн музей	Аюуш бурхан	2	2015	VIVID 9i
5	Дүрслэх урлагийн музей	Язгуурын таван бурхан	1	2015	VIVID 9i
6	Дүрслэх урлагийн музей	Язгуурын таван бурхан	3	2016	VIVID 9i
7	Дүрслэх урлагийн музей	Цагаан дарь эх	1	2016	VIVID 9i
8	Дүрслэх урлагийн музей	Суварга	1	2016	VIVID 9i
9	Чойжин ламын сүм музей	Язгуурын таван бурхан	1	2016	VIVID 9i
10	Богд хааны ордон музей	Ногоон дарь эх	1	2016	VIVID 9i
11	Ховд аймгийн музей	Олдворын тэвш	1	2016	VIVID 9i
12	Хархорум музей	Гэрэлт хөшөөний хэсэг	4	2016	VIVID 9i
13	Эрдэнэ Зүү музей	Ловонбадамжунай	1	2017	VIVID 9i
14	Эрдэнэ Зүү музей	Гомбо гүр	1	2017	VIVID 9i
15	Эрдэнэ Зүү музей	Юмсэргиймаа	1	2017	VIVID 9i
16	Эрдэнэ Зүү музей	Ногоон дарь эх	1	2017	VIVID 9i
17	Эрдэнэ Зүү музей	Бурхан багш	1	2017	VIVID 9i
18	Эрдэнэ Зүү музей	Майдар	1	2017	VIVID 9i
19	Богд хааны ордон музей	21 Дара эх	5	2017	VIVID 9i
20	Төв аймгийн музей	Өндөр гэгээний жирав	1	2018	VIVID 9i
21	Монголбанк Эрдэнэсийн сан	Алтан аяга	2	2018	VIVID 9i

Хүснэгт-1

**2014-2018 онд дараах 6 аймгийн нутаг дэвсгэрт байрлах 20 ширхэг үл хөдлөх дурсгалыг 3D бүртгэн баримтжуулсан. (Хүснэгт2)**

Nº	Аймаг	Сүм	Дурсгалын нэр	Тоо ширхэг	Он	3D scanner
1	Булган	Баяннуур	Шороон бүмбагар	1	2013, 2015	Faro focus 3D
2	Сүхбаатар	Дарьганга	Ламтын хүн чулуу	2	2014	VIVID 9i
3	Сүхбаатар	Дарьганга	Хөргийн хөндийн хүн чулуу	6	2015	VIVID 9i
4	Сүхбаатар	Дарьганга	Хөхөлийн хөндийн хүн чулуу	2	2016	VIVID 9i
5	Хэнтий	Хэрлэн	Гэлэн хөшөө	1	2016	VIVID 9i
6	Архангай	Өлзийт	Өөлд бэйсийн Жүйдийн дуганы чимэглэл	4	2015	VIVID 9i
7	Дундговь	Эрдэнэдалай	Үнстийн хийдийн дээвэр ваар	4	2016	VIVID 9i

Хүснэгт-2

Музейн үзмэрийг 3D лазер сканнераар баримтжуулахад хүндрэл, бэрхшээл харьцангуй бага байдаг. Үл хөдлөх дурсгалуудад дараах бэрхшээлүүд нийтлэг тулгарч байна. Үүнд:

Байгаль цаг уурын таагүй байдал: Цаг улирлын байдаас шалтгаалж 3D баримтжуулалтын

ажил ихэнхдээ дулааны улиралд хийгдэг хэдий ч бороо, цас болон хүчтэй салхи нь хээр хөдөө ажиллахад хүндрэлтэй байх тал бий.

Орон нутгийн иргэдийн үл ойлголцол: 3D скан хийх гэж буй хөшөө дурсгалын байрлах орон зай, овор хэмжээ болон дүрслэлийн

онцлог зэргээс шалтгаалж зарим тохиолдолд байрнаас нь хөдөлгөх шаардлага гардаг. Үүнээс үүдэн зарим үед орон нутгийн иргэдтэй үл ойлголцох байдал үүсч, баримтжуулалтын ажил хийхэд хүндрэлтэй. Тодорхой жишээ дурьдавал; 2016 онд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын иргэд

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

төрийн ажлыг үл хүндэтгэн, өөрсдийн шүтлэг бишрэлээр хэт дөвийлгөн хандаж ажилд саад учруулнаар тус сумын төвд байрлах Хаан, хатан хэмээх хүн чулуунуудыг 3D баримтжуулах ажлыг хийлгүүлэгүй юм.

Нэг талаас орон нутгийн иргэдийн сүсэг бишрэл, итгэл үнэмшлийг хүндэтгэн үзэх нь зүй ёсны боловч нөгөө талаас соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй улсын мэргэжлийн байгууллагын ажлыг хэвийн явуулж, хамтран ажиллах нь орон нутгийн удирдлага болоод ард иргэдийн үүрэг төдийгүй соёлын өвийг хамгаалахад оруулж буй тэдний хувь нэмэр юм. Иймэрхүү хүндрэлтай байдал археологийн хайгуул судалгаа хийдэг мэргэжлийн байгууллагуудад ч тулгарч байсан жишээ цөөнгүй бий.

Түүх, соёлын үл хөдлөх



Хэнтий аймаг. Хэрлэн сум. "Гэлэн" хэмээх хүн чулуун хөшөөний 3D модель.

дурсгалыг урт хугацаанд тогтвортой хадгалж хамгаалахад хамгийн чухал хүчин зүйлийн нэг бол орон нутгийн иргэдийн соёлын өвийн хадгалалт хамгаалалтын талаарх мэдлэг, боловсрол болохыг дэлхий нийтээр онцолж, үүнд ихээхэн анхаарах болжээ. Иймд улсын хэмжээнд соёлын

өвийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудаас орон нутгийн удирдлагууд, нутгийн иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, харицан ойлголцож, хамтран ажиллах нь нэн чухал юм.

**А.Энхбаяр**

МУИС-ийн профессор

## ВИРТУАЛ МУЗЕЙ

МУИС-ийн харьяа Компьютер график, мультимедиа судалгааны нээлттэй лаборатори, Соёлын өвийн үндэсний төв, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей хамтран Өндөр гэгээн Занабазарын хосгүй үнэт бүтээлүүдийг гурван хэмжээст лазер сканнерын туслаамжтай өндөр нарийвчлал хэмжээгээр цахим бүртгэл оруулах ажлыг 2017-2018 онд хийв. Улмаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын дэмжлэгтэйгээр мэдээллийг ашиглан гурван хэмжээст загвар бүтээн анх удаа Монголын музейнүүдийг "Виртуал үзмэр"-ээр баяжуулах ажлыг санаачлан хэрэгжүүлээ.

Энэхүү виртуал музейд Өндөр гэгээний мутрын бүтээлүүд болох "Ногоон дара эх" (Богд

хааны музей), "Цагаан дара эх" болон Язгуурын таван бурхан "Машид гийгүүлэн зохиогч", "Цаглашгүй гэрэлт", "Үйл бүтээгч", "Үл хөдлөгч", "Эрдэнэ үүсгэгч" (Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музей) зэрэг үзмэрүүд хамрагдav.

Үзэгчдийн сонирхол татах зорилгоор цахим орчинд гурван хэмжээст бүтээлийн загвар бүрт тохиорох өвөрмөц шийдвэрлэх бүхий дэглэлт, панограм хийсэн нь үзмэрийн утга агуулгыг улам нэмсэн байна. Жишээ нь: Энх цагийг бэлгэдэж Сарыдагийн хийдийн тууриас олдсон Язгуурын таван бурханы баримлыг 1000

хувилж бадамлянхуа цэцгийн дэлбээн дээр байрлуулахдаа ижилсэн сүрэглэх бодь гөрөөс, үзэмжит сайхан байгаль дэлхийн амирлангуй орчинд нийлэн нэгдэх мэт өвөрмөц шийдвэрлээр харуулжээ.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Ц.Жаргалсайхан

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч

### ДЭЛХИЙН ӨВД БҮРТГЭГДСЭН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВҮҮД

**А**ливаа үндэстэн, угсаатны соёлын биет бус өв нь тэдний өвөрмөц онцлог, дүр төрхийг илэрхийлэх нэрийн хуудас болж байхын хамт тэрхүү өвөрмөц онцлог нь бусдыг нөхөн сэлбэж нийт хүн хүн төрөлхтний соёлын бүрэлдэхүүн болох учиртай. Бид үндэсний бахархал болсон, монголчуудын амьдралын хэв маягаас гарсан Хүн төрөлхтний мэлмий, сонорыг мляасан гайхамшигт өвүүдээ НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО-д бүртгүүлэх гэж хичээдэг. Дэлхийн боловсрол, соёл, шинжлэх ухааны гол байгууллагад тухай өвийг бүртгүүлэх нь нарийн, өндөр шалгууртай, судалгаа, шинжилгээ шаардсан, өндөр хариуцлагатай, чухал ажил. Энд манай Соёлын өвийн үндэсний төв бусад холбогдох яамд, төрийн болон ТББ байгууллагууд, өвлөн уламжлагчид, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж

ирлээ. ЮНЕСКО “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” Конвенцийг 2003 онд баталж, 2005 онд Монгол Улс энэхүү конвенцид нэгдэн орсон бөгөөд түүний дагуу “Хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт” болон “Яаралтай хамгаалах соёлын биет бус өвийн дэлхийн жагсаалт”-д үндэстэн, угсаатны бүлэг, хувь хүмүүсийн соёлын биет бус өвийн зүйлүүдийг бүртгэн түгээн дэлгэрүүлж, хамгаалан хөгжүүлж байна. Биет бус өвийг хамгаалах, холбогдох хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн биет бус соёлын өвийг хүндэтгэх, түүнийг хүлээн зөвшөөрөхийн чухлыг орон нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд ойлгуулах, олон улсын хамтын ажиллагаа болон тусlamжаар хангах зэрэг нь дээрхи конвенцийн зорилго хэмээн заасан байдаг. ЮНЕСКО-ийн холбогдох баримт бичгүүд нь даяаршлийн эрин болох XXI зуунд эх хэл, соёл түүний олон зүйлийг



Монгол Лимбэчдийн Уртын Дуу Хөгжмийдөх Уламжлалт Арга Барил – Битүү Амьсгaa .

хамгаалж харилсан ойлголцох нь даян дэлхийд амгалан тайван, тогтвортой, илүү утга учиртай амьдралыг тогтоох найдвартай баталгаа болохыг дэлхийн олон улс үндэстэн, хүн зонд харуулж байгаагаараа үнэ цэнэтэй юм.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас **ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтаа бүртгэгдсэн өвүүд :**

1. Монгол Ардын Уртын Дуу (2008)- Уртын дуу бол дуу дуулах бүхий л ур, арга чадамжийг хослон аль ч төрийн дуунаас удаан уужим уянгалуулан дуулдаг Монгол үндэстний сонгодог урлаг юм. Уртын дуу нь төрийн хүндэтгэлт ёслол, баяр наадам, ард түмний эрхэм сайхан ёс заншил, зан үйл, хурийн найрын сур жавхaa, энх мөнхийн бэлгэдэл.
2. Морин Хуур Хөгжмийн Уламжлалт Урлаг (2008)- Морин хуур нь цар багтаамж ихтэй, хөг аялгуу илэрхийлэх чадвар сайтай, хийц ба эгшиг дуурсалын төгс төгөлдөр зохицлыг олсон монгол үндэсний хөгжмийн зэмсэг. Монголчууд төрийн ёслол, баяр наадам, хурийн найр, ёслол хүндэтгэл, ахуйн холбогдолтой зан үйлийн үед морин хуурын ая эгшигээ өргөдөг уламжлалтай.
3. Монгол Баяр Наадам (2010)- Монгол баяр наадам нь Хурдан морины уралдаан, Бөхийн барилдаан, Сурын харваанаас бүрдэх ба уламжлалт спорт ардын аман болон язгуур урлаг, ардын мэдлэг арга ухаан уламжлалт гар урлал, үндэсний идээ ундааны эрхэм сайхан өвийг өөртөө багтаасан Монгол үндэсний баяр наадмын цогц жишээ.
4. Монголын Уламжлалт Хөөмийн Урлаг (2010)- Хөөмий нь хүний амьсгалын

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- болов өгүүлэхүйн эрхтнийг хөгжмийн зэмсэг болгон уран гоё ая эгшиг үүсгэдэг Хүн-хөгжим юм. Монголчууд хөөмийн урлагийг урлагийн "зэмсгийн" төгс чанарт хүргэн өвлөн хөгжүүлж байгаагараа хүн төрөлхтний, соёлын өв санд нэгэн онцгой содон хувь нэмэр оруулж байна.
5. Шувуучлахуй (2012)- Шувуучлахуйн нэг гол хэлбэр болсон Бүргэдээр ан хийх зан үйлийн амьд уламжлал манай улсын казах үндэстний дунд өнөөг хүртэл язгуур хэв шинжээрээ ахуйн зан үйл, ёс заншил, аман билгийнх нь салшгүй хэсэг болж өвлөгдөн уламжлагдсан ирсэн.
  6. Монгол Гэрийн Уламжлалт Урлал, Зан Үйл (2013)- Гэр бол монгол үндэстний, гоо сайхны мэдрэмж, уламжлалт гар урлал, бэлгэдлийг цогцоор хадгалсан, хүн амьдрахад тохь тухтай, байгалийн гаралтай бүтээгдэхүүнээр өвч бүтдэг, уран барилгын өвөрмөц шийдэл бүхий нүүдэлчин монголчуудын уламжлалт эко сууш бөгөөд тойрог суурьтай, тал бөмбөрцөг маягийн хэлбэртэй, гэрэл, дулаан болон агаарын зөв солилцоотой, газар хөдлөлт, салхи шуурганд тэсвэртэй, бөх бат, эвхэж задалж угсргадах оньсон зохиомжтой, том бага янз бүрийн хэмжээтэй хийж хэрэглэж болдог онцлогтой.
  7. Монгол Шагайн Харваа (2014)- Хашлага модон шагайгаар хасаа бай харваж оролцогчид нь цэцмэргэнээ сорьж тоглодог эртнээс уламжлагдсан монгол тоглоом наадам.
- ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаарлагатай Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвүүд:**
8. Монгол Тууль (2009)- Монгол тууль бол хэдэн түмэн мөр шүлгээс бүрдэг монголчуудын аман зохиолын аварга том туурвилилээ. Туульсын эдгээр бүтээлүүд нь монголчуудын домогзүй гүн ухаан, уран сайхны сэтгэлгээний охь шим, үлгэр, домог, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг төдийгүй түүль хайлах арга өвөрмөц аялгугүй багтаасан соёлын гайхамшигт өв.
  9. Монгол Ардын Бүжиг: Бий Биелгээ (2009)- Үндэстэн ястнуудын ахуйн амьдрал, ёс заншил, зан үйл, сэтгэлийг биеийн уран гоё хөдөлгөөнөөр илэрхийлэг бүжгийн уламжлалт урлаг. Монгол ардын Биелгээний хөдөлгөөн нь голчлон гэрийн бага орон зайд хагас сууж гарaa атгах, цацах, цээж мөрөө огшом сугсрах, чичиргэх, хөлөө солбих, алхах, гишгэх, биеэ гүнхалзуулах, сүялзуулах, түялзуулах зэргээр бүждэг эртний өвөрмөц урлаг.
  10. Монгол Цуур Хөгжмийн Уламжлалт Урлаг (2009)- Монголын эртний хөгжмийн өвөг зэмсгийн нэг болох цуур нь уртааш барин үлээж хөгжимдэг З нүхтэй модон үлээвэр хөгжмийн зэмсэг юм. Цуурын хийц нь энгүүн эгэл мэт боловч нүүдэлчин монголчуудын олон зууны туршид өвлөн хөгжүүлж ирсэн хөгжмийн өвөрмөц урлаг.
  11. Монгол Лимбэчдийн Үртын Дуу Хөгжимдэх Уламжлалт Арга Барил – Битүү Амьсгаа (2011)- Лимбэдэх битүү амьсгааны урлаг нь монгол ардын уртын дууны ая, эгшиглэгээний онцлогт бүрэн зохицсон, ялангуяа уртын дуунд эхнээс нь дуустал огт таслахгүй уран гоё ая, аялгуугаар уужим сунгаж эгшиглүүлэн хамсардаг өвөрмөц урлаг.
  12. Монгол Уран Бичлэг (2013)- Монгол уран бичлэг нь Монголчууд эртнээс олон янзын бичиг үсэг зохиож хэрэглэхдээ түүгээрээ уран гоёор бичиж уншдаг ур авьяас, арга ухааныг хөгжүүлэн өвлөн уламжилж ирсэн соёлын гайхам сайхан өв бөгөөд Монгол бичгийн уран бичлэг нь нарийн тогтсон тиг, зурлагтай, хичээнгүй, таталган, гүйлгэн, эвхмэл зэрэг уран бичих тигийн олон арга хэлбэртэй .
  13. Ингэнд Ботго Авахуулах Зан Үйл (2015)- Нүүдэлчин ард түмний энэхүү энэрэнгүй хосгүй гайхамшигт зан үйл нь дэлхийн бусад улс үндэстэнд тэр бүр тохиолддоггүй ховор үзэгдэл юм. Ингэнд голсон ботгыг нь эсвэл өөр ингэй өнчин ботгыг авахуулаадаа түүнийг уяраан аргадаж байж авахуулдаг өвөрмөц
- 
- Монгол Гэрийн Уламжлалт Урлал, Зан Үйл.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

зан үйлийг дэлхийд жинхэнэ энэрэнгүй нандин өв хэмээдэг.

**14. Ул Овоо Тахих Монгол Зан Үйл /2017/-Энэхүү зан үйл нь бөөгийн зан үйтэй холбоотой боловч бурхны шашны гүн ухаан, сав шим ертөнцийн тухай онол мэдлэгээр чимэглэн хөгжиж ирсэн, уул усны эздийг урин дуудаж, баярлуулан баясгаж хүсэл даатгалаа илэрхийлж буй зан үйл.**

Эдгээр өвүүд ЮНЕСКО-д бүртгэгдэж Дэлхийн данстай болоод байна. Дээрх өвүүдийг хүн төрөлхтний биет бус соёлын өвийн шилдэг дээж хэмээн зарлан тунхагласан нь нүүдэлчин монголчуудын бүтээн бий болгосон давтагдашгүй өвөрмөц эдгээр өвүүдийг дэлхий дахины түгээмэл, хосгүй гайхамшигт үнэ цэнэтэй бөгөөд, түүний хүмүүнлиг чанарыг хүлээн зөвшөөрч, монгол үндэстнээс нийт хүн төрөлхтний соёлын өв санд оруулсан хувь нэмэр хэмээн үнэлсэн хэрэг юм. Нөгөөтэйгүүр амсар их хариуцлага хүлээлгэсэн хэрэг хэмээн ойлгож болно.

Соёлын биет бус өв энэхүү давтагдашгүй, өвөрмөц соёлыг хадгалж хамгаалан, хөгжүүлж дархлаажуулах нь бид бүхний ариун зорилго, хүн төрөлхтний соёлд оруулах үнэтэй хувь нэмэр учраас, бид хичээх ёстой. Өөрөөр хэлбэл: Монголчуудын оюун санааны амьдралын гол цөм болсон Соёлын биет бус өвийг өнөө цагт болж байгаа томоохон өөрчлөлт: -суурьшиж, хотжиж, аж үйлдвэржин даяаршиж, нүүдлийн иргэншил эргэлт буцаалтгүй задарч байгаа нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл байдал дунд хадгалж, хамгаалах, хойч үедээ өвлүүлэх нь тулгамсан зорилт болж байна. Соёлын өвийн хадгалалт хамгаалалт, соёлын үйл ажиллагаанд бодлогын шинэчлэлт хийх зайлшгүй нөхцөл бүрдэж байна гэсэн үг.

Орчин цагийн гол үзэгдэл болох даяаршил, хотжилт, техник технологийн дээрх хөгжлийн нөлөөгөөр суурин соёл иргэншил

давамгайлах болж, хүн амын амьдралын хэв маяг хурдаатай өөрчлөгджэх байгаа энэ цаг дор дэлхийн улс орнууд үндэсний уламжлалт соёлоо дээдлэх замаар хүнийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж эхэллээ.

давхаалыг анхааран үзэх, Давхцаал үүсэж буй өвийн зүйлийг судлах, нэн яаралтай нэр дэвшүүлэх ажлын хэсгийг байгуулж тэргүүн ээлжинд эдгээр өвийн зүйлүүдийг яаралтай хамгаалах шаардлагатай болон төлөөлөл зэрэг эрэмбээр



Монгол Ардын Бүжиг: Бий Биелгээ.

Өнөөдөр 21 аймгийн музейгээс соёлын биет бус өвийн шинэчилсэн бүртгэлээр баяжуулж ҮНБМСанд нийт анхан шатны бүртгэл бүртгэлтэй өвлөн уламжлагчдын тоо 8383 болж нэмэгдсэн тоон үзүүлэлтэй байна. Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх явцад 177 Соёлын биет бус өвийн төрөл зүйл бүртгэгдээд байна. Бид цаашид монгол мэдлэг, арга ухаан, гар урлал, бусад өвийн олон төрөл зүйлийг ЮНЕСКО-гийн бүртгэл оруулах нь чухал. 2014 оны ЮНЕСКО-гийн Засгийн газар хоорондын Хорооны “Үйл ажиллагааны удирдамж”-ийн шинэчлэлийн дагуу 10-аас дээш (манай улс 14 өв бүртгүүлсэн) Соёлын биет бус өвийн зүйл бүртгүүлсэн оролцогч улс орнуудын Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлж буй баримт бичгийг 2 жил тутамд нэг өвийн зүйл авч хэлэлцэх заавар гарсан. Цаашид Монгол Улсаас гадна өөр улс орон, бус нутагт оршдог соёлын өвийн

нь ЮНЕСКО-д нэр дэвшүүлэх, Шаардлагатай тохиолдолд бусад оронтой хамтран бүртгүүлэх нөлөөллийн ажил хийх, Нэр дэвшүүлэх өвийн зүйлийн судалгааны ажлын хэсгийг томилж 2-3 жилийн өмнөөс бэлтгэн боловсруулж, ЮНЕСКО-д илгээж хэвших зэрэг анхаарах болоод тулгамдсан асуудлууд бидний өмнө байна.

Биет бус соёл гэдэг судлаад барагдашгүй их ч хамгаалж нандигнахгүй бол өчүүхэн эмзэг соёл юм. Тиймээс “Үүрхайг ухах тусам дундарна, оюуныг ухах тусам ундарна” хэмээсэн үгийг санан маш их хичээж, яарч, нандигнан хайрлаж, хадгалах ёстой зүйл-Соёлын биет бус өв юм.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Ж.Насанжаргал**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч

**Э**дүгээ хүртэл уламжлагдаж ирсэн нийт Монгол үндэстэн, угсаатны соёлын бүхий л өв нь түүхэн тодорхой орон зайд, цаг үеийн аль нэг хэсгийг бүрнээ төлөөлсөн байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдолтой, тийм л баялаг сан хөмрөг билээ. Түүний дотор Соёлын биет бус өв онцгой юм. Соёлын биет бус өв нь хүмүүсийн бүлэг, хамт олон, зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан үйлүүд, үзүүлж харуулах болон илэрхийлэх урлаг, арга үйлдлүүд, мэдлэг болон арга ухаан, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл хийгээд соёлын орон зайд хамарсан өргөн хүрээтэй ойлголт, ухагдахуун юм.

Өнөөгийн Монгол Улсын хүн ам харьшангуй цөөн ч Халх, Буриад, Хамниган, Дөрвөд, Баяд, Өлөд, Торгууд, Хошууд, Захчин, Мянгад, Дархад, Алтайн Uriанхай, Барга, Үзэмчин, Дарьганга, Хотон, Хотгойд, Сартуул, Казах, Тува, Цаатан гэсэн олон угсаатан, үндэстний цөөнхөөс бүрдэгээрээ өвөрмөц онцлогтой. Монгол угсаатан бүр нь түүх, соёлын эртний арвин уламжлалтайн дээр энэ нь түүхийн урт удаан хугацааны явцад бүрэлдэн төлөвшиж, хувьсан хөгжикж, өөрийн гэсэн утга соёлын өвөрмөц нэгдлийг бүрдүүлсэн түүхтэй. Монгол угсаатан бүрийн өв соёл нь нийт монгол түүргатан, үндэстний соёлын нийтлэг бүрэлдэн тогтох төлөвшихөд өөр өөрсдийн хувь нэмрийг оруулсаар ирсэн бөгөөд үе үеийн монголчуудын үндэсний бахархал, бусад угсаатан үндэстнээс тод ялгарах өвөрмөц дүр төрх болсоор ирсэн үнэ центэй юм. Үүнийг л Монголчууд бид хадгалж хамгаалж байх түүхэн үүрэгтэй билээ.

Монгол Улс нь ЮНЕСКО-гийн 2003 оны Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцид нэгдэн

## НҮҮДЭЛЧИН МОНГОЛ “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДАМ-2018”

орсон орны хувьд олон улсын гэрээ, Конвенцийг хэрэгжүүлэх болон Монгол Улсын Их Хурлаар 2014 онд баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн 39.2. дахь заалтыг удирдлага болгон соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2018 оны 8 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд “Соёлын биет бус өвийн их наадам-2018”, “Нүүдэлчин монгол” нэрийн дор амжилттай болж өндөрлөв.

Тус наадмыг ЮНЕСКО-ийн 2003 онд батлагдсан “Соёлын биет бус өвийн хамгаалах тухай Конвенц”-ийн зарчим, үзэл баримтлалын дагуу 5 ай савын төрлийг хамруулж, оролцогч аймаг тус бүр отогийн зохион байгуулалтад орж өөрийн нутаг дахь соёлын биет бус өвийн төрөл зүйлийг олон нийтэд сурталчилан таниулсанаараа онцлог болсон юм.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллага 1966 оноос Бүх ард түмний урлагийн их наадам, 1991 оноос Ардын урлагийн их наадмыг 5 жил тутам зохион байгуулж ирсэн уламжлалтай. 1921 оноос хойш Ардын хувьсгалын ойнуудыг тохиолдуулан сайн дурын уран сайханчдын улсын уралдаан зохион байгуулдаг болж, улмаар 1966, 1971, 1976, 1981, 1986 онд Бүх ард түмний урлагийн их наадам, 1983, 1988 онд Язгуур урлагийн улсын үзлэг, 1992 онд Монгол туургатны дуу хуурын наадам, Ардын билиг зүйчдийн уралдааныг орон даяар зохион байгуулжээ. 5 жил тутам зохиож ирсэн Бүх ард түмний урлагийн их наадмыг 1991 оноос эхлэн “Ардын урлагийн их наадам” хэмээн нэрлэн, зөвхөн ардын язгуур, уламжлалт урлагийн төрөл, зүйлийг хамруулан явуулах болж 1991, 1996, 2001 онд улсын хэмжээнд зохион байгуулж 2011 онд уламжлалт гар урлалын төрлийг хамруулан зохион байгуулжээ. Харин 2006 онд Их Монгол Улс байгуулагданы 800, Ардын хувьсгалын 85 жилийн ой, Үндэсний их баяр наадмаар 800 уртын дууч, 800 морин хуурчдын



“Нүүдэлчин монгол” Соёлын биет бус өвийн их наадам.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

тогтолтыг анх удаа нийслэл Улаанбаатарт хийсэн байна.

“Соёлын биет бус өвийн Их наадам – 2018”-ийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенци, салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, дэмжин хөгжүүлэх, судалж сурталчилах үйл ажиллагааг өргөжүүлэх, таван ай савын хүрээнд Соёлын биет бус өвийн зүйлүүд, өвлөн уламжлагчдыг тодруулан алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах зорилгын хүрээнд дараах зорилтуудыг чиглэл болгон зохион байгуулав. Үүнд:

1. Соёлын биет бус өвийн 5-н ай савын хүрээнд: эх хэл болон аман уламжлал, илэрхийлүүд; гар урлал; байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, арга ухаан; уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам; язгуур урлагийг хөгжүүлж, сэргээж, таниулан сурталчлах, өвлөн уламжлуулах;
2. Соёлын биет бус өвийн Их наадмын хүрээнд олон нийтэд соёлын биет бус өвийн бүхий л төрлүүдийг биечлэн үзүүлэх, суралцах боломжоор хангах, өвлөн уламжлагчид, сонирхогчдын хүрээг нэмэгдүүлэх;
3. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын үйл ажиллагааг дэмжих;
4. Соёлын биет бус өвийн төрөл зүйлийн хадгалалт хамгаалалтад дүгнэлт хийх, түүнийг хадгалж хамгаалах бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, соёлын өвийн судалгааг эрчимжүүлэх зэрэг болно.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/22 тоот тушаалаар Соёлын биет бус өвийн Их наадмын удирдамжийг батлан, I шатны шалгаруулалтыг 2018 оны 6 дугаар сард аймаг, нийслэлийн



“Нүүдэлчин Монгол” Соёлын биет бус өвийн их наадам, нээлтийн үйл ажиллагаа

хэмжээнд, II үе шатны үйл ажиллагаа буюу Соёлын биет бус өвийн Их наадмын төвлөрсөн арга хэмжээг 2018 оны 8 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Хүй долоон худагт зохион байгуулсан.

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын авьяас билэг, ур чадвар, хөдөлмөр бүтээлийг үнэлж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас Монгол Улсын Засгийн газрын шагнал “Соёлын тэргүүний ажилтан” тэмдгээр 60 хүнийг, “Тэргүүний ардын авьяастан” тэмдгээр 60 хүнийг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны “Жуух бичиг”-ээр 70 хүнийг, наадмын үр дүнээрдэмтэн судлаачдаас бүрдсэн шүүгчдийн үнэлгээний дүнг үндэслэн Соёл, урлагийн газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн А/49 тоот тушаалаар Өмнөговь аймаг Тэргүүн байрт шалгарч хүндэт өргөмжлөл 20.000.000(хорин сая) төгрөг, Ховд аймаг Хоёрдугаар байрт шалгарч хүндэт өргөмжлөл 15.000.000 (арван таван сая) төгрөг, Дундговь аймаг Гуравдугаар байрт шалгарч хүндэт өргөмжлөл 10.000.000 (арван сая) төгрөг, Увс, Хөвсгөл аймаг Тусгай байрт шалгарч хүндэт өргөмжлөл 5.000.000 (таван сая) төгрөгөөр тус бүр шагнагдлаа.

Мөн аймаг, нийслэлийн дүүргээс Их наадмын II шатны шалгаруулалтад оролцож

шүүгчдийн бүрэлдэхүүний шийдвэрээр онцгой авьяас, чадвартай гэж дүгнэгдсэн 134 хүнийг “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч” үнэмлэх, алдаршуулах медалаар тус тус шагнасан байна.

Монгол үндэстний Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, дэмжин хөгжүүлэх, судалж сурталчилах үйл ажиллагааг өргөжүүлэх, таван ай савын хүрээнд соёлын биет бус өвийн төрөл зүйлүүд, өвлөн уламжлагчдыг тодруулан алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг баяжуулах зорилготой “Соёлын биет бус өвийн Их наадам-2018” нь үндсэн зорилгоо бүрэн биелүүлсэн, Монгол Улсын бүх газар нутгийн өв соёлыг хамруулсан, өвийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд анхан шатны үнэлгээ, дүгнэлт өгсөн чухал арга хэмжээ болсон хэмээн дүгнэж байна.

Мөн “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДАМ – 2018” мэдээ, мэдээлэл, гэрэл зургийн цомог номыг бүтээсэн бөгөөд тус цомогт наадмын анхан шатны болон хоёрдугаар шатны үйл ажиллагаа, холбогдолтой гэрэл зургууд, наадмын шинжээч, шүүгчдийн зүгээс 5 ай савын хүрээнд гаргасан үнэлгээ, дүгнэлт, шүүмж зэрэг цогц мэдээллийг агуулсан бүтээл хэвлэгдэн үзэгч, үншигчдын гартаа хүрсэн байна.

**Г.Анхсанаа, Н.Бат-Эрдэнэ**  
**Соёлын өвийн үндэсний төв**  
**Б.Батдалай, Ч.Амартувшин**  
**ШУА-ийн Археологийн хүрээнд**

2017 оны 12-р сарын 4-ний өдөр Увс аймгийн Давст сумын нутагт орших Шүдэн ууланд хувиараа давс олборлолт явуулж байсан иргэд газрын гүнээс эртний хатмал шарил болон модон багажууд илэрснийг аймаг, сумын холбогдох байгууллагуудад мэдээлсний дагуу Давст сумын Засаг даргын захирамжаар дээрх олдворыг хамгаалалтад авч, ажлын хэсэг байгуулан дурсгалт газрын ойр орчмоос олдсон зарим олдвор хэрэглэгдэхүүнийг баримтжуулан сумын Соёлын төвд шилжүүлсэн байна.

Дээрх шарил болон олдворыг Увс аймгийн Засаг даргаас БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газар, Соёлын өвийн үндэсний төвөөс мэргэжлийн баг ирүүлж нөхцөл байдалтай танилцаж, тодорхой дүгнэлт гаргаж, дараагийн шатны арга хэмжээг авч ажиллахыг хүссэн 1/1413 тоот албан бичгийг аймаг, сумын Засаг даргын захирамж, ажлын хэсгийн тэмдэглэл, гэрэл зургийн хавсралтын хамт 2017 оны 12-р сарын 11-нд БСШУСЯ-ны сайд Ц.Цогзолмаад хандан ирүүлсэн юм.

Энэ хүсэлтийн дагуу Соёлын өвийн үндэсний төв (Г.Анхсанаа, Н.Бат-Эрдэнэ), ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгээс (Б.Батдалай, Г.Одмагнай, жолооч

## ШҮДЭН ҮҮЛЫН ДҮРСГАЛЫГ АВРАН ХАМГААЛСАН ТУХАЙ

Л.Ойдовдагва) хамтарсан хээрийн шинжилгээний анги зохион байгуулж 2018 оны 1-р сарын 05-ныас 12-ны хооронд Увс аймгийн Давст сумын нутаг Шүдэн ууланд дурсгалыг авран хамгаалах ажлыг хийж гүйцэтгэв.

Тус дурсгал нь Шүдэн уулын урд энгэрт давс олборлож байсан ухмалын дотор эгц хананд газрын хөрснөөс доош 4.7 м гүнээс анх илэрсэн (зураг 1) бөгөөд биднийг очиход шарилын баруун тал ил гарсан байдалтай байлаа.

Хатмал шарил бүдүүн ширхэгтэй шаргал, бор өнгийн утсаар нэхэж хийсэн моринд эмээлийн ард тохиж явах зориулалттай бололтой тааран богц (зураг 5) дээр өвөл цагийн эсгий давхарласан үстэй дээл, эсгий давхарласан малгай, нэхий гуталтай өмссөн (зураг 6) хүний толгой нь зүүн хойд зүгт хандан доош харсан байдалтай байсан ба баруун гараа энгэртээ нугалгалж, хоёр хөл нь их биеийн доор дарагдсан байв. Мөн шарилын баруун талаар хананд хэд хэдэн модон багажны үлдэгдэл цухуйж байв. Өмнө нь хатмал шарилын орчмоос модон хүрз, модон муна,

модон лантуу, модон гадас, модон ооль зэрэг 40 гаруй модон багаж олдсон билээ.

Хатмал шарилын дороос хамт олдсон тааран шууданд байсан хэдэн жижиг давс болон давс олборлоход ашиглаж байсан багаж зэргээс үзвэл эрт цагт Шүдэн уулын энгэрт цооног ухан давс олборлож байх явцдаа широондаа дарагдан амь эрстсэн бололтой юм (Батдалай нар., 2018).

Шарилыг Улаанбаатар хотод авч ирэн цэвэрлэгээ хийж (Оюунчимэг, 2018), хадгалалт хамгаалалтын зохистой нөхцөлд шилжүүлэхийн өмнө рентген шинжилгээ хийлгэхэд өвчлөл гэмтэл бэртлийн хувьд баруун болон зүүн хацар яс, зүүн талын нүдний ухархай, хамар эрүүний яс дайрсан цөмөрсөн хугарал, мөн зүүн талын шаант яс 1/3 хэсэгтээ хөндрөн хугаралтай, 24-27 орчим насны эрэгтэй хүн байна. Шүдэнд ямар нэг өвчлөл, гэмтэл ажиглагдаагүй бөгөөд мөчдийн ясаар тодорхойлоход уг хүн 170-172 см өндөртэй, гавлын ясны хэлбэр шинжийг харахад монголжуу болон европжуу завсрын хэв шинжтэй байна




Хатмал шарил олдсон газар

Тус ажилд туслацаа үзүүлсэн Увс аймгийн ОНС музейн хамт олон, Давст сумын Засаг даргын орлогч Д.Ариунаа, Соёлын төвийн эрхлэгч С.Батмагнай, Хилийн 0246-р салбарын Заставын дарга, ахмад Ж.Золбоо, орлогч дарга, ахлах дэслэгч Ж.Асим нар болон тус салбарын нийт албан хаагч, хилчдэд талархал илэрхийлье.



Авран хамгаалах малтлага хийж байгаа нь.



Хатмал шарилд хийсэн C14-ийн  
шинжилгээ.

(Номуундарь, 2018).

Мөн Хатмал шарилын шүдэнд Япон Улсын “KASOKU” задлан шинжилгээний лабораториид хийсэн он цаг тогтоох шинжилгээгээр VIII-IX зуунд хамаарах нь тогтоогдсон байна (株 加速器分析研究所, 2018).

Энэ бүгдээс үзвэл дээрх хатмал шарил болон модон багажууд нь Шүдэн ууланд наанадаж Уйгурын үеэс давс олборлон, ашиглаж байнсыг нотлох, эртний нүүдэлчдийн үйлдвэрлэлийн түүхэнд холбогдох чухал баримт юм.



Хатмал шарилын анхны байдал.



Авран хамгаалах малтлага хийсэн багийн бүрэлдэхүүн.

Батдалай Б., Одмагнай Г., Анхсаная Г., Бат-Эрдэнэ Н. Увс аймгийн Давст сумын нутгаас илэрсэн хатмал шарилыг археологийн авран хамгаалах судалгаа хийсэн ажлын тайлан. ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв. Улаанбаатар, 2018  
Номуундарь Г. Шүдэн уулаас олдсон хатмал шарилд рентген шижилгээ хийсэн товч тайлан. “Мөнгөнгүүр” эмнэлэг. Дүрс оношилгооны тасаг. Соёлын өвийн үндэсний төв. Улаанбаатар, 2018  
Оюунчимэг О. Увс аймгийн Давст сумын Шүдэн уулаас илэрсэн хатмал шарилыг цэвэрлэсэн ажлын тайлан. Соёлын өвийн үндэсний төв. Улаанбаатар, 2018  
(株) 加速器分析研究所. 放射性炭素年代測定結果報告書 (AMS測定) 2018

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Ж.Насанжаргал**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч

### СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАГДЛАА

Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа монгол угсаатны олон бүлгийн соёлын биет бус өвийг олж илрүүлэх, судлах, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 68 дугаар тогтоолоор "Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг 2019-2023 онд хэрэгжүүлэхээр баталлаа. Хөтөлбөрийн хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- Соёлын биет бус өвийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, соёлын биет бус өвийг хамгаалах конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Соёлын биет бус өвийн судалгаа, бүртгэн баримтжуулалт, бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, боловсронгуй болгох;
- Соёлын биет бус өвийн талаар бүх нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг салбар хоорондын хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулах;
- Соёлын биет бус өвийн мэргэжилтийг чадавхижуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Зорилт	Шалгур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	
				Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
<b>Бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх бусад шалгур үзүүлэлтүүд</b>							
1	1. Соёлын биет бус өвийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, соёлын биет бус өвийг хамгаалах конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	Судлагсан эрх зүйн баримт бичигт санал өгсөн байдал	Тоо	2019	1	2023	2
		Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан дүрэм, журам	Тоо	2019	1	2023	4
		Гадаад улс орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээр	2019	1	2023	3	
		ЮНЕСКО-д бүртгүүлсэн өв	Тоо	2019	14	2023	16
2	2. Соёлын биет бус өвийн судалгаа, бүртгэн баримтжуулалт, бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, боловсронгуй болгох	Үзлэг, судалгаа	Тоо	2019		2023	2
		Мэдээллийн сангийн баяжилт, цахим сан үүсгэлт	Тоо	2019		2023	2
		Тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллага	Хувь	2019	10%	2023	70%
3	3. Соёлын биет бус өвийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг салбар хоорондын хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулах	Зохион байгуулсан уралдаан, наадам, түүнд хамрагсад	Тоо	2019	1/550	2023	2/1200
		Үндэсний агуулгатай монгол уран бүтээлийн эзлэх хувь	Хувь	2019	10%	2023	60%
		Соёлын өвийн гарын авлага, хөтөлбөр	Тоо	2019	2	2023	8
		Соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжсэн төсөл, нэвтрүүлсэн дэвшилтэт технологи	Тоо	2019	15	2023	40
4	4. Соёлын биет бус өвийн мэргэжилтийг чадавхжуулах, өвлөн уламжлагчдыг дэмжих	Өвлөн уламжлагч	Тоо	2019	98	2023	120
		Зохион байгуулсан сургалт, түүнд хамрагсад	Тоо	2019	3/120	2023	10/500
		Шинэ залуу уран бүтээлчдийг дэмжсэн арга хэмжээ	Тоо	2019	5	2023	10
		Шавь сургалтад суралцагчид	Тоо	2019	1	2023	22
		Соёлын биет бус өвийг сурталчилсан байгууллага	Тоо	2019	-	2023	8

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 43 дугаар тогтоолоор "Морин хуур, уртын дуу", 2007 оны 159 дүгээр тогтоолоор "Монгол хөөмэй", 2009 оны 10 дугаар тогтоолоор "Монголын уламжлалт бий, биелгээ", 2011 оны 357 дугаар тогтоолоор "Монгол түүль" үндэсний хөтөлбөрийг тус тус боловсруулан батлуулж, 2005-2014 онд багтаан хугацаанд нь хэрэгжүүлэв. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 72 дугаар тогтоолоор баталсан "Монгол шуур" хөтөлбөрийг 2016 онд хэрэгжүүлж дуусгасан билээ.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Ж.Насанжаргал**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч

### **ЗҮҮН БҮСИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ӨВЛӨГДӨЛ БА ГЭЭГДЛИЙН СУДАЛГАА**

(Хэнтий, Дорнод аймаг)

**ЮНЕСКО**-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийн 11, 13с дугаар зүйл, “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 141 дүгээр зүйлийн 141.1.4, Соёлын өвийн төвийн захирлын А/31 тоот тушаал, 2017 оны 06 сарын 09-ны өдрийн ЮНЕСКО, Соёлын өвийн төвийн хооронд байгуулсан 4500333187 тоот гэрээ, Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн 2010-2017 оны анхан шатны бүртгэлийн дүнг тус тус үндэслэн Зүүн бүс нутгийн Хэнтий, Дорнод аймаг дахь цөөнх болсон үзэмчин, барга, буриад, хамниган угсаатны бүлгийн соёлын биет бус өвийг олж тогтоох өнөөгийн нөхцөл байдлын суурь судалгааг Соёлын өвийн үндэсний төв, Хэнтий аймгийн орон нутгийг судлах Музей, Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газар болон хувь судлаачаас бүрдсэн хамтарсан баг 2017 оны 07 дугаар сарын 16-наас 08 сарын 15 хүртэл 30 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.

2017 оны байдлаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан (щашид УНБМС

гэнэ)-д Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчаар 8383 гаруй авьяас билэгт хүмүүс бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 60 хувь нь ардын язгуур урлаг, 23 хувь нь гар урлал, 11 хувь нь эх хэл, аман уламжлал, 4 хувь нь үндэсний уламжлалт баяр ёслол, зан үйл, 2 хувь нь байгаль ертөнц, цаг улиралтай холбогдол бүхий ардын амьдрал ахуйн уламжлалт мэдлэг, арга ухааны ангилалд хамаарч байна. Энд ардын язгуур урлаг, гар урлалаас бусад илэрхийлүүд маш цөөн хувийг эзэлж байгаа нь тэдгээр өвийн олон төрөл зүйлээс устаж үгүй болж буйг нотлон харуулж байна. Дээр дурссан нийт өвлөн уламжлагчийн 7,2% буюу 580 өвлөн уламжлагч Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт оршин сууж байна. Зүүн бүсийн угсаатны бүлгүүдийн өвөрмөц онцлог, зан үйл халхжих, нэгдэн нийлэх, орчин цагийн суурьшмал амьдралын хэв маяг зэрэг олон хүчин зүйл нөлөөлж устан үгүй болох шалтгаан болж байгаа нь энэхүү судалгааг хийх зайлшгүй шаардлага гарч байна.

Судалгааны баг Хэнтий



Өвлөн уламжлагч Д. Цэрэнханд, Дорнод аймаг Дашибалбар сум.


аймгийн Биндэр, Дадал, Батноров, Норовлин, Батширээт сүмд орших буриад зон олны соёлын биет бус өвийг олж тогтоох, түүн дотор “Эх хэл болон аман уламжлал”, “Уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам”, “Байгаль болон сав ертөнцийн тухай уламжлалт мэдлэг, арга ухаан” зэрэг ай савд хамрах өвийн

#### **Хээрийн судалгааны дүн мэдээ.**

Хэнтий аймгийн Биндэр, Дадал, Батноров, Норовлин, Батширээт сүмд орших буриад зон олны соёлын биет бус өвийг олж тогтоох, түүн дотор “Эх хэл болон аман уламжлал”, “Уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам”, “Байгаль болон сав ертөнцийн тухай уламжлалт мэдлэг, арга ухаан” зэрэг ай савд хамрах өвийн

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

зүйлсийг илрүүлэх зорилгоор судалгааны ажил өрнөсөн. Судалгаанд нийт давхардсан тоогоор нийт 33 өвлөн уламжлагч, давхардсан тоогоор буюу өв хавсарсан 54 өвлөн уламжлагч хамрагдаж, үлгэр, домог, марзай, буриад хурим, тоонот тахих, даахь үргээх, оршуулгын зан үйл, буриадын уламжлалт тоглоом,



Хэнтийн аймгийн судалгаа хийгдсэн сумдын байршил.

талх барих арга технологи, буриад, хамниган ан агнуур, төрж амаржихтай холбогдолтой зан үйл, арьс шир боловсруулах, морь хатгах, уламжлалт анагаах ухаан, буриад дээл, малгай, шавар зуух, тууз цохих, ходок тэрэг, түйсэн сав хийх арга зэрэг 30 төрөл зүйлийг олж тогтоов. Үүнд:

- Биндер сүм – 6 өвлөн уламжлагч,
- Дадал сүм – 11 өвлөн уламжлагч,
- Батноров сүм – 1 өвлөн уламжлагч,
- Норовлин сүм – 6 өвлөн уламжлагч,
- Батширээт сүм – 9 өвлөн уламжлагч тус тус хамрагдсан байна.

Дорнод аймгийн Баян-Үул, Булган, Гурванзагал, Дашбалбар, Цагаан-Овоо, Сэргэлэн, Хөлөнбуйр сумд орших буриад, үзэмчин, барга угсаатны бүлгийн соёлын биет бус өвийг олж тогтоох, түүн дотор "Эх хэл болон аман уламжлал",

"Уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам", "Байгаль болон сав өртөнцийн тухай уламжлалт мэдлэг, арга ухаан" зэрэг ай савд хамрах өвийн зүйлсийг илрүүлэх зорилгоор судалгааны ажилыг хийж гүйцэтгэсэн болно. Судалгаанд нийт давхардсан тоогоор нийт 33 өвлөн уламжлагч хамрагдаж, ерөөл, тоонот тайх, буриад хурим, оршуулга, шагай няслах, бэлзэг нүүх, барга хурим, оршуулга, цаг агаар шинжих ёс, морь шинжих, анагаах ухаан, арьс шир боловсруулах, морь хатгах, үзэмчин хурим, үзэмчин дээл, ходок тэрэг хийх арга технологи зэрэг 18 төрөл зүйлийг олж тогтоов. Үүнд:


- Баян-Үул сүм – 3 өвлөн уламжлагч,
- Булган сүм – 1 өвлөн уламжлагч,
- Гурванзагал сүм – 1 өвлөн уламжлагч,
- Дашибалбар сүм – 6 өвлөн уламжлагч,
- Цагаан-Овоо сүм – 10 өвлөн уламжлагч,
- Сэргэлэн сүм – 4 өвлөн уламжлагч,
- Хөлөнбуйр сүм – 7 өвлөн уламжлагч тус тус хамрагдсан байна .

Энэхүү судалгаагаар Хэнтий, Дорнод аймгийн 12 сумын угсаатны бүлгийн Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч болон төрөл зүйлийг олж тогтоох хээрийн судалгаанд давхардсан тоогоор нийт 84 өвлөн уламжлагч хамрагдаж, 48 өвийн зүйлийг судалгаагаар олж тогтоон , 51 хүнээс 2727 минутын дуу, дурс бичлэг, 5036 ширхэг гэрэл зургаар баримтжуулан ҮНБМСанд 420 орчим зураг сонгон архивлав.

Судалгааны ажлын үеэр сумдын соёлын төвийн ажилтнуудад зориулан соёлын биет бус өвийн үндсэн ойлголт, хууль эрх зүй ба биет бус өвийг бүртгэх арга зүйн сэдвээр төрөлжсөн сургалт зохион байгуулсан.

Судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан "Зүүн бүсийн Соёлын биет бус өв" судалгааны бүтээлийг хэвлүүлж олон нийт болон судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч аймаг, сумдаад хүргүүлэн түгээн сурталчилсан.

Өнөөгийн суурьышмал амьдралын нөлөө, хэрэгшээ шаардлагаа даган угсаатны бүлгүүдийн амьдралын хэв маяг хэрхэн өөрчлөгдөн соёлын биет бус өвийн ховор олон төрөл зүйлс ашиглагдахаа болж мартагдах, устан үгүй болж байгааг энэхүү судалгаанаас харж болно. Мөн хүн амын хувьд дийлэнх болох халх, буриад угсаатанд цөөн тоотой хамниган, барга, үзэмчингүйд уусан саармагжиж өөрсдийн онцлог зан үйл, заншил, соёлын олон төрөл зүйл мартагдан нийтлэг шинж төрхтэй болж байна. Гэсэн хэдий ч соёлын өвөө хайрлан хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх чин хүсэл эрмэлзэлтэй олон олон өвлөгчдийн ачаар өнөөг хүртэл олон зуун жилийн турш өвлөгдөн ирсэн оюуны соёлын дундаршгүй эх ундаргыг цааш өвлүүлэн хөгжүүлэхэд Орон нутгийн Удирдлага, соёлын



Дорнод аймгийн судалгаа хийгдсэн сумдын байршил.

өвийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаач нарын оролцоотойгоор авран хамгаалах үйл хэрэг цаашид улам өргөжин хөгжинэ гэдэгт итгэж байна.

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### A. Саруул

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Соёлын биет бус өвийн шинжээч

### СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА

**С**оёлын өвийн үндэсний төв, Монгол дахь Швейцарын хөгжлийн агентлагтай 2016 оны 7 дугаар сарын 7-ны өдөр “Монголын соёлын өвийн хадгалалтад нөлөөлж буй хүчин зүйлсийн газарзүйн зурагт лавлах” төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, соёлын өвийн хадгалалт хамгаалалтад сөргөөр нөлөөлж буй байгаль, нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлж газрын зурагт буулгах, Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтад нөлөөлж буй хүчин зүйлсийн газарзүйн зурагт лавлах ном боловсруулж, хэвлүүлэх зорилтын хүрээнд “Соёлын өвийн эрсдэлийн атлас” судалгааны бүтээлийг хэвлүүлсэн байна.

“Соёлын өвийн эрсдэлийн атлас” дахь Соёлын биет бус өвийн эрсдэлийн судалгааг хийхдээ:

#### 1. МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

- Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллээс өвлөн уламжлагчдын насхилтын мэдээллийг боловсруулах,
- Насны бүтцийг 31 өвийн төрөл зүйлд бүлэглэсэн.
- Насны бүтцийг эрсдэлийн ангилалд хуваасан.
- Бүлэглэсэн мэдээллийг газар зүйн мэдээллийн системд шилжүүлсэн.

#### 2. ЭРСДЭЛИЙН ГАЗРЫН ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

- 31 өвийн төрөл зүйлд насны бүтцээр эрсдэлийн тодорхойлж газрын зураг гаргах,
- 31 өвийн төрөл зүйлийн насны эрсдэлийн зургийг холбогдох ай савд давхцуулан төрөлжсөн эрсдэлийн зураг боловсруулах,
- Төрөлжсөн эрсдэлийн зурагт орон зайн давхцуулалт хийх Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын насхилтын эрсдэлийн нэгдсэн зураг гаргах.


2010-2016 онд аймаг, сумын Соёлын биет бус өвийн бүртгэл, мэдээллийн сангаас Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд цуглагдсан 177 Соёлын биет бус өвийн төрөл зүйлийн мэдээллээс монгол үндэстэн, угсаатныг төлөөлөх, нийтлэг 31 өвийн төрөл зүйлийг сонгосон болно.

Эх хэл болон аман уламжлал, илэрхийлүүд	Үндэсний уламжлалт зан үйл ёслол, баяр наадам	Ардын язгуур урлаг	Байгалийн болон сав өртөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга ухаан	Ардын уламжлалт гар урлал
Үриа дуудлага	Хурдан морь	Морин хуур	Цагаан идээ боловсруулах мэдлэг арга ухаан	Уран хатгамал, зүү ороох урлал
Ерөөл	Шагайн харваа	Исгэрээ	Хурдан морь шинжих, сойх мэдлэг, арга ухаан	Морин хуур урлал
Магтаал	Сурын харваа	Лимбэ	Уламжлалт анагаах ухаан	Уран дархны урлал
Бөхийн цол	Хуримын зан үйл	Ардын дуу	Адуутай холбоотой зан үйл, мэдлэг, арга ухаан	Монгол гутал урлал
Хурдан морины цол		Бий бийлгээ	Мал хатгах, эмчлэх уламжлалт ухаан	Сийлбэр урлал
Тууль		Үртүн дуу		Эсгий урлал
		Хөөмэй		Үндэсний хувцас урлал
				Арьс ширэн урлал
				Гар урлал

Сонгосон 31 өвийн төрөл зүйлийн өвлөн уламжлагчдын насны дунджийг сүм бүрт тооцон гаргаж эрсдэлийн 3 бүлэгт хуваан авч үзсэн.

Эрсдэлийн утга	Насны дундаж
Их эрсдэлтэй	60-аас дээш
Дунд эрсдэлтэй	40-59
Бага эрсдэлтэй	40-өөс доош

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



"Соёлын өвийн эрдэлийн атлас" бүтээлүүдийг соёлын өвийн шат, шатны шийдвэр гаргагч, бүртгэл, мэдээллийн сангийн ажилтнууд болон соёлын өвийг хамгаалагчидад түгээх зорилгоор тус тус 300 ширхэг хэвлэсэн болно.

Соёлын өв нь байгаль, хүрээлэн буй орчин, хүн, хүний нийгмийн хөгжлийн үйл явцтай хүйн холбоотойн учир Соёлын биет бус өвийн тархалт, гээгдэл, хадгалалт, хамгаалалтанд өвлөн уламжлагчдын насжилт хэрхэн нөлөөлж байгааг Монгол орны газар зүйн мэдээллийн системийн туслаамжтайгаар энд анх удаа хөндөв.

Судалгаа нь соёлын биет бус өв болоод түүний өвлөн уламжлагчдын газар зүйн байршил, насны бүтэц түүний үр нөлөөллийг тодорхойлон Монгол

орны нийт нутаг дэвсгэрийг хамруулан газар зүйн мэдээллийн системд тулгуурлан хийсэн нь энэхүү судалгааны шинэлэг тал юм.

Соёлын биет бус өв болон түүний өвлөн уламжлагчдын тархалт, сөргөөр нөлөөлөх эрсдлийн хүчин зүйл, түүний нөлөөллийн талаарх суурь судалгаагаар Соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалтын менежмент, төлөвлөгөөг боловсруулах, үүсэж болох эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг Соёлын биет бус өвийг сэргээн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, хадгалж хамгаалахад удирдамж, чиглэл болгоход бодит мэдээллийн сан бүхий загварчлал бий болгосон нь соёл судалын салбарт шинэ судалгаа, судлагдахууны эхлэлийг тавьсанаараа энэхүү

бүтээл Соёлын биет бус өвийг хамгаалахад суурь судалгаа болох практик ач холбогдолтой гэж үзжээ.

**С.Чинзориг**  
Сэргээн засварлагч

## “ХЭРЛЭН БАРС”-ЫН ЦАМХАГИЙН БЭХЖҮҮЛЭЛТ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТЫН АЖИЛ

Дорнод аймгийн Цагаан-овоо сумын нутагт орших 10 дугаар зууны үед холбогдох Хэрлэн барс хотын цамхаг суваргын барилгын одоогийн байгаа эх төрх байдалд нь бэхжүүлэх, сэргээн засварлах ажлыг 2015-2016 онд хийж гүйцэтгэсэн. 2013 оноос эхлэн уг цамхаг барилгын түүхэн судалгааны ажлыг эхлүүлэн, 10 дугаар зууны Хятаны үеийн барилгын хэв загваруудтай харьцуулан судалсны үндсэн дээр уг барилгын архитектурын зураг төсөл болон сэргээн засварлалтын ажлын төлөвлөгөө боловсруулсан юм. Зураг төслийн дагуу сэргээн засварлах ажлыг үе шат дараалан:

1. Шамхагийн чулуун суурийн хэсгийг сэргээн засварлалт;
2. Хөх тоосго бэлтгэх, цамхагийн тоосгон өрлөгийн сэргээн засварлалт;
3. Барилгын оройн усны хамгаалалтын дээвэр, ус зайлцуулах хоолой, шагайвч цонхнуудад хамгаалалтын тор, дам нуруунуудыг дээш татах бэхзлэгээ;
4. Шамхагийн гадна талд газар хөдлөлт чичиргээний нөлөөллөөс хамгаалах

хамгаалалтын бэхзлэгээ бус байрлуулах;

5. Шамхагийн гадна ханын өрлөгийн завсарт шохойн чижжээс, чулуун суурин дээр шавар хучилт хийх 5 үндсэн ажлуудын хүрээнд хийгдсэн болно.


Шамхагийн барилгыг анхны эх төрх байдалд нь ойртуулан сэргээхэд уг суваргад ашигласан тоосгоны хэмжээ, чанартай ижил 8-10 мянян ширхэг хөх тоосго хэрэглэгдэх шаардлагатай болсон тул тоосгыг уг дурсгалын орчимд бэлтгэхээр төлөвлөсөн юм. Хөх тоосго хийх технологийн дагуу тоосгоны шатаах зуух барих, шавар татах, хэвлэх, шатаах ажлыг БНХАУ-ын мэргэжилтнүүдтэй хамтран (тоосго шатаах зуухыг Шаньси мужийн хөх тоосгоны зуух барих мэргэжилтэн Chang Ming-suo биечлэн удирдсан) хийлээ

2015 онд барилгын нөхөн сэргээн засварлалтад хэрэглэгдэх хөх тоосгоо технологийн дагуу бэлтгэхийн сацуу цамхагийн дотор ханын 1 ба 2 дугаар давхрын хэсгийг нөхөж сэргээн засварлав. Ажлын зургийн дагуу цамхагийн

тоосгон өрлөгийг хийхдээ хуучин тоосгонд бэхжүүлэгч түрхэж, тоосгон өрлөгийн завсарт ган холбоосуудыг хавчуулан бэхжүүлсэн. Өрлөгийн тоосгоны завсарт шохойн лагшингийн чижжээс найруулж чигжсэн.

Нэгдүгээр давхарын дотор талд 5 хэсэг газарт их, бага хэмжээтэй нурсан ханын өрлөгийг засварлан нөхөлт хийсэн. Шамхагийн гадна талын өрлөгийн нуралттай хэсгийг хэсэгчлэн сэргээх ажлыг цамхагийн баруун урд, баруун, баруун хойд, зүүн урд, зүүн талын хэсгүүдийн 1 болон 2 дугаар давхрын залгааны шаталсан өрлөгүүдэд зургийн дагуу хийв.

2016 ондажлын зургийн дагуу цамхагийн модон хаалга, нэгдүгээр давхарт байрлуулах модон хийц бүхий шат, ус зайлцуулах хоолой, цамхагийн дээвэр зэрэг ажлуудыг зохих технологийн дагуу хийж гүйцэтгэсэн. Цамхагийн нэгдүгээр давхрын ханын өрлөгийг сэргээн засварлах ажлын зурагт ханын суурийг шаталсан өрлөггүй тэгш байхаар тусгагдсан байв. Гэвч цамхагийн зүүн урд талын хананд сууринаас дээш 4, 5, 6 дугаар үеийн тоосгон өрлөг тус ханын тэгш өрлөгтэй өнгөний тоосгонос



Дорнод аймаг. Цагаан-овоо сум. Хэрлэн барс хотын Суврагийн 3D модель.

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

18-20 см гадагш татаж өрсөн байсныг судалгаагаар тогтоо. Дээрх зүүн урд талын шаталсан өрлөгтэй, цамхагийн давхруудын бусад талуудыг ижил байдлаар өрж тоосгон өрлөгийн завсарт хийх арматур төмөр бэхэлгээ, шавар барьцаалдуулагч уусмалыг зургийн дагуу хийж сэргээн засварлав.

Нэгдүгээр давхрын хаалганы өргөний хэмжээ ажлын зурагт 120 см-ийн хэмжээтэй тусгагдсан хэдий ч суурийг малтан судлах судалгааны явцад хаалганы өргөн 190 см хэмжээтэй байсан нь тодорхой болсон тул хаалганы өргөний хэмжээг ажлын зургийн хэмжээнээс өөрчлөн 190 см, өндрийг ажлын зурагт тусгасан хэмжээгээр хаалга хийж байрлуулсан. Дөрөв, тав зургаадугаар давхруудын гадна ханын өрлөгийн нуралт бусад давхруудыг бодвол харьцангуй бага хэдий ч бүх талуудад их бага хэмжээгээр нурсан гэмтлүүд маш их байлаа. Энэ давхруудын хагарч хугарсан тоосгонуудад тоосго залгах сольж засварлахын тулд хуучин тоосгыг тэгшлэж засварлах ажлуудыг хийсэн. Мөн тоосгоны булан эмтэрч сэтэрсэн бага зэргийн хугаралтай тоосгонуудыг засварлалгүй үлдээв.

Уг цамхагийн оройн хэсэгт борооны усны хамгаалалт дээвэр хийх, дээврийн усыг цамхагийн дотор талаар дамжуулан гадагш зайлзуулах ажлыг ажлын зургийн дагуу дээвэр хийхэд 7мм уголник төмөр болон дээврийн зориулалттай поликарбонат хавтан ашиглав. Цамхагийн 3,4,5,6 дугаар давхруудын модон шалны дэр, дам нуруунуудын хойд талын үзүүр хэсгүүд нь ханын тоосгон өрлөг дотор орж бэхлэгдсэн, урдаа үзүүр хэсгүүд нь хоорондоо углуургаар холбогдож байсан хэдий ч он цагийн уртад өмхөрч муудан углуургууд хугарч салсанаар доош үнжих, зарим хэсгүүд нь хугарч унах байдлаар ихэдгэмтсэн байлаа. Дээрх давхруудын дам нурууны үлдэгдлүүдийг одоогийн байгаа байдлаар нь хамгаалах хэрэгтэй гэж үзэж углуурга салсан, доош үнжсан нуруунуудын доод талд нь тулгуур ивээс уголник төмөр



Суврага сэргээн засварлалт, бэхжүүлэтийн өмнө.



Суврага сэргээн засварлалт, бэхжүүлэтийн дараа.



Суврага сэргээн засварласан ажлын баг бүрэлдэхүүн.

барьж түүнээс дээш нь бүрээстэй трассоор цамхагийн дээд хэсэгт байрлуулсан хөндлөвч төмөр нуруунаас татлага хийж дээш сойж татах байдлаар хамгаалалтын бэхэлгээ хийв.

Цамхагийн 3, 5, 6 дугаар давхруудын залгаа өрлөгийн хэсгүүдэд газар хөдлөлтийн чичирхийллээс хамгаалах хамгаалалтын бүслүүрийг ажлын зургийн дагуу байрлуулав. Бэхэлгээний бүсэнд FRP: SST-sheet 240 синтетик материал, SSTResin 220- ерохид шавуун материал

ашиглав.

Хэрлэн барс хотын цамхагийг сэргээн засварлах ажил нь монголын сэргээн засварлагч мэргэжилтнүүдэд дурсгалт уран барилгыг сэргээн засварлах онол, практик хосолсон арга ажиллагаанд суралцуулсан, чадавхийг нь дээшлүүсэн үр дүнтэй ажил болсон юм.

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

**Г.Нямдорж**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын дарга

**А.Мөнгөнцож**

Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч

## ШОРООН БУМБАГАРЫН БУНХАНТ БУЛШНЫ ХАНЫН ЗУРГИЙГ АВРАН ХАМГААЛАХ, ХҮУЛБАРЛАХ АЖИЛ

**Б**улган аймгийн Баяннуур сумын нутагт орших Шороон бумбагарын ханын зургийн зарим дүрслэлээс хуулбар хийх ажлыг ССАЖЯ-ны захиалгаар "Түүх, соёл" ХХК, Соёлын өвийн үндэсний төв хамтран 2013-2014 онд хийж гүйцэтгэсэн. 2013 оны 8 дугаар сард Соёлын өвийн үндэсний төв, Япон улсын "Сайшики Секкей" сэргээн засварлах компанийтай хамтран бунханы үүдэвчний 2 талын ханан дээрх хоёр луу, хүн зурсан зургийг 1x1 хэмжээ бүхий хүрээ зураас (рисунок) зурагалыг бэх болон маркер ашиглан 2 төрлийн хальсан дээр буулгаж авав. Үүнд:

- PED хальсан дээр бэх ашиглан бийрээр хүрээ контур зураасыг татав. Уг хальс нь нэг талдаа цавуутай акрелик бэхэн хэвлэлийн хальс ба энэ нь бэх ашиглан бийрээр зураасыг татахад бэх урсахгүй, арчигдаж арилахаас сэргийлэгдсэн байна.

- Энгийн хальсан дээр маркер ашиглан дүрсийг

буулгасан.

Дүрслэлийг буулгаж авсан хэсгийн ханын зургийн хуулбарыг хийхэд шаардлагатай өнгө будгийн болон одоо байгаа байдлыг энгийн фото зураг болон хэт улаан тяяны фото зургаар баримтжуулалт хийв. Хэт улаан тяяны гэрэл зураг нь энгийн нүдээр ажиглахад харагдахгүй бүдэг зураасыг илрүүлдэг ба энэ нь хуулбарыг шинээр хийх ажил чухал ач холбогдолтой баримт болдог.

- Фотог ашиглан одоо байгаа буюу хуучирсан байдлаар нь хуулбарлах арга нь: 1x1 хэмжээгээр хэвлэсэн өндөр чанартай фото хэвлэлээс цаасан дээр шууд хуулбарлах арга юм. Бэлдсэн хэвлэлийн дээр зориулалтын цавуу шохойгоор цардсан муутуу цаас дэлгэж түүнийгээ бөөрөнхий голд ороож хэвлэлийн дээгүүр өнхрүүлэн шууд буулгадаг. Энэ арга нь хуучны уламжлалт арга бөгөөд энэ аргаар



Хуулбар хийх ажлын явц.



Хуулбарын хэсэг.

хуучны танка зураг, уламжлалт уран зургийн хуулбарыг хийдэг ба өнөө үед ч технологийн дэвшилтэй хослуулан хэрэглэдэг байна.

- Ханын зургаас буулгаж авсан бэхэн болон маркер дүрслэлийг ашиглан хуулбарыг анхны буюу шинэ мэт байдлаар хуулбарлах арга нь: Хальсан дээр буулгаж авсан дүрсийг ашиглан мөн адил бэлдсэн муутуу цаасан дээр дүрсийг буулган дараа нь өнгө зураасыг буулгадаг. Энэ аргаар хийсэн хуулбар зураг нь хуучин зургийн гэмтэл алга болсон хэсгийг нөхөж шинэ байдлаар буюу анх бүтээгдэж байсантай ижил ойролцоо маягаар хуулбарлан сэргээх арга юм.

Гэрэл зурагт өнөөгийн байгаа байдлаар хуулбарласан болон анхны төрх байдлыг үзүүлэх зорилгоор хийсэн хоёр янзын хуулбарын туршилтыг харуулав.

2014 онд уг бунхант булшны ханын зургийг бүрэн эхээр нь 1x1

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

хэмжээтэй хуулбар хийх ажлыг манай сэргээн засварлах хэлтэс бие даан хийж гүйцэтгэлээ.

Үг хуулбарын дүрслэлийг эх зургаас хальсан дээр гараар хуулбарлан буулгаж авсан 1x1 хэмжээтэй хуулбар хувийг эх болгосон. Бүнхны ханын овон, товон гадаргын хэвийг гипсээр хуулбарласан ба тухайн орон нутаг дахь шар шавар, мөн Улаанбаатар хотын ойролцоо шар шаврын орд газруудаас шаврын дээж авч хуулбарт хэрэглэв.

Хуулбарын арын үндсэн хавтанг зөөж угсралад хөнгөн, бат бөх, хэлбэр төрх нь алдагдахгүй байх хөнгөн цагаан зөгийн үүр хавтангаар хийсэн. Зургийн үндсэн материал болох шавар ўе давхаргыг тогтоох зорилгоор уг хавтанд тор нааж, шаврыг нарийн өвстэй хольж зуурان шавар давхаргыг хийж хатаан, шингэн шохойн грунт тавьж үндсэн эх дэвсгэрийг бэлдсэн болно.

Үүний дараа эх зургаас хуулбарлаж авсан дүрслэлүүдийг хэмжээ харьцааны дагуу бэлдсэн дэвсгэр форматууд дээр буулгаж бэх, минерал болон зарим синтетик пигмент зэргээр хуулбарын өнгө будгийг хийллээ. Ханын зургийг хуулбарлах ажлыг 2014 оны 9 дүгээр сараас 2015 оны 1 дүгээр сар хүртэлх зургаан сарын хугацаанд хийсэн бөгөөд Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд үзэсгэлэн зохион байгуулан сурталчилжээ.



Хуулбар хийх ажлын явц.



Хуулбарын хэсэг.



Хуулбар хийсэн ажлын бүрэлдэхүүн.

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

### **Б.Мягмарсүрэн**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч

## ҮЗҮҮР ГЯЛАНГИЙН ХАДНЫ ОРШУУЛГЫН ОЛДВОРУУДЫН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

**2**016 оны 4 дүгээр сард доктор Ч.Мөнхбаяр ахлагчтай Ховд Их сургууль, Ховд аймгийн музейн хамтарсан судалгааны баг тус аймгийн Мөнххайрхан сумын “Борт баг”-ийн нутаг “Үзүүр гялан” гэдэг газарт орших байгалийн ургаа бул чулууг дагуулан газар хөндийлөн ухсан оршуулгын байгууламжнаас эртний үед холбогдох нэгэн дурсгалыг авран хамгаалах зорилгоор малтан гаргасан юм.

Үг хадны оршуулгаас гарсан олдворуудын сэргээн засварлалтын ажил үндэснээ бүртгэл баримтжуулалт, материалын судалгаа, сэргээн засварлалт гэсэн чиглэлээр хийгдлээ. Манай төвийн сэргээн засварлагч мэргэжилтэнгүүд 2000 оноос хойш Хэнтий аймгийн “Бухын хошуу”, Дорноговь аймгийн “Нартын хад”, Баянхонгор аймгийн “Дүгүй цахир” зэрэг газруудаас олдсон хадны оршуулгын олдворуудыг сэргээн засварлаж туршлагажсан нь энэ удаагийн сэргээн засварлалтад үр дүнгээ үзүүлсэн.

“Үзүүр гялан”-гийн хадны оршуулгын онцлог нь эмэгтэй хүний өмсгөл дээл, хувцас анх удаа иж бүрэн байдлаар олдсон олдвор ба антропологи, археологи, угсаатны зүйн чухал ач холбогдолтой эд өлгийн зүйлс юм.




Юуны өмнө “Үзүүр гялан”-гийн эмэгтэй хүний хатмал шарилыг битүү ороосон эсгий боолтыг дэлгэж задлахаас өмнө олдворыг гэмтээлгүйгээр бие, гар, хөлийн хөдөлгөөний байрлал болон өмсгөсөн дээл хувцас, дагалдах эд зүйлсийг тогтоох зорилгоор “Сонгдо” эмнэлгийнхний тусламжтайгаар компьютер томографийн рентген зургийг авсан билээ. Сэргээн засварлахын өмнө компьютерийн рентген зураг нь эд өлгийн зүйлсийн дотоод бүтцийг тогтоох тохиромжтой арга юм.

Тухайлбал, эхний үзлэгээр хатмал шарилын цээжний зүүн талын хэсэгт жижиг арьсан уут байгааг тогтоосон ба сүүлд шарилыг дэлгэн задалсны дараа битүү боолттой уг уутны рентген зургийг дахин авч, дотор нь 2 ширхэг зүү шиг металл эд байгааг илрүүлэв.


Сэргээн засварлагчид “Үзүүр гялан”-гийн олдворуудыг сэргээн засварлахын өмнө олдвор нэг бүрийн материалын судалгаа, гэмтэл, бохирдлыг тэмдэглэсэн гар зураг үйлдэж, гэрэл зургаар баримтжуулав.

Хадны оршуулгын олдворууд гол төлөв олон жилийн хүр широо, барагшун, мэрэгч амьтдын ялгадас, шавжны үүр өндөг зэрэг зүйлсээр бохирдсон боловч барагшуны баас нь хүрц үнэрээрээ олдворыг хамгаалсан байх магадлалтай. Даавуу болон эсгий өдлэлүүд маш ихээр мэрэгч амьтдад идэгдэж гэмтсэн боловч гандаагүй, хуурайшиж хэврэгшээгүй, уян хатан чанар харьшангуй сайн. Мод, метал өдлэлүүд зэврэлт, хагаралт, өгөршил харьшангуй бага байлаа.

Тус төвийн лабораторит толь, хутга, төмөр тогоо, гутлын тоног, хазаарын чимэг зэрэг 5 ширхэг металл эдлэлд бүтцийн



“Үзүүр гялан”-гийн эмэгтэй хүний хатмал шарилын рентген зураг.



Хатмал шарилын цээжний хэсэгт байсан арьсан уутан дахь 2 ширхэг зүү шиг металл эд.

судалгааг “Horiba XGT-5200 X-Ray” микроскоп багаж ашиглан хийж, гарсан үр дүн мэдээллийг Ховд Их сургуулиас уг олдвор олдсон хил орчмын бүс нутгаас илэрч судалгаа шинжилгээнд хамрагдсан зарим металл эд өлгийн зүйлсийн

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ




Эсгий.



Даавуу.



Арьс нэхий.



Processing Time : P3				
XGT Dia: 100 µm X-ray tube vol. : 50 kV				
Current: 1.000 mA				
X-ray Filter: Nonexistence Cell: Nonexistence				
Element	Mass [%]	2sigma [%]	Atomic [%]	Intensity [cps/mA]
13 Al K	2.17	0.50	4.98	2.18
14 Si K	12.16	0.41	26.84	32.26
26 Fe K	1.95	0.04	2.17	127.04
27 Co K	0.36	0.02	0.38	27.71
28 Ni K	0.38	0.02	0.40	25.87
29 Cu K	52.18	0.49	50.90	3679.38
42 Mo K	0.00	0.01	0.00	0.02
50 Sn K	22.92	0.47	11.97	72.53
53 I K	0.07	0.19	0.03	0.10
82 Pb L	7.80	0.18	2.33	102.52

Хүрэл толины металлын бүтэц нийтлэгэн график ба хүснэгт. "Үзүүр гялан"-гийн хүрэл толь ба түүний гадаргууг 0.50 тт нарийвчлалтай авсан зураг



Цэвэрлэгээний явц.

өгөгдөлтэй харьцуулан судалсан.

Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Н.Баярхүү, адuu судлаач Вильям Тейлор /William Taylor, USA/ нар адлууны ясан дээр анхан шатны судалгааг, МУИС-

ийн багш, антропологич доктор, Д.Түмэн, М.Эрдэнэ нар хүний ясны антропологийн судалгааг, СҮИС-ийн багш, доктор Б.Мөнхцэцэг дээл, хувцасны эсгүүрийн судалгааг хийж байна. Мөн БНТУ-ын судлаачдын баг ирж ажилласан

ба хүний хатмал шарил, морь зэрэг эд өлгийн 9 төрлийн зүйлсээс нийт 18 ширхэг дээжийг АНУ-ын "BETA Analytic" хэмээх лабораторид шинжилгээнд явуулсан байна. Уг шинжилгээгээр олдворуудын цаг хугцаа нь X зуунд холбогдохыг

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

тодорхойлсон хариу ирүүлжээ.

Энэхүү олдворт даавуу, зөвлөн эдлэлийг төрөлжүүлэн үзвэл:

- цагаан эсгий, хоёр төрлийн бор эсгий, ноолууртай зөвлөн эсгий, хар хялгасан ноостой цайвар эсгий зэрэг 5 төрөл,
- ноосон даавуу, хөвөн даавуу, торго г.м 40 орчим даавуу,
- 6 төрлийн мал амьтны арьс нэхийй байна.

Хадны оршуулгын олдворуудад хүн, мал амьтны яс, эсгий даавуу, арьс, яс, мод, төмрөөр хийгдсэн эд өлгийн зүйлс зонхилох ба тэдгээрийн материалын шинж чанараас хамааран бэхжүүлэлт, сэргээн засварлалтыг хийж гүйцэтгэлээ.

Даавуун болон эсгийгээр хийсэн эд өлгийн зүйлд хуурай болон усан цэвэрлэгээ хийсэн ба ингэхдээ химийн бодис огт хэрэглээгүй юм. Цаашдаа олдворууд он удаан жил хадгалагдах учраас ямар нэгэн химийн бодис хэрэглэх тохиromжгүй тул энгийн цэвэрлэгээг гол болгон баримтлан ажилласан.

Даавуу, эсгий эдлэлийн бохирдлыг хуурайгаар цэвэрлэсний дараа нэрмэл усан цэвэрлэгээг хийсэн ба чийгийг шингээж авах байдлаар уг эдийн

анхны хэв байдалд оруулан дэлгэн хатаалаа.

### **Усан цэвэрлэгээ**

Нэмэл усаар үзмэр бүрийг 8-10 удаа зайлж угаасан

### **Хуурай цэвэрлэгээ**

Зарим угааж норгож болохгүй эдлэлийг чийгтэй даавуу тавьж зөвлөн товших аргаар нарийн тоос шороог цэвэрлэв.

Олдворуудыг анх хүлээн авахдаа зөвхөн ил харагдаж тоолж болохуйц эд зүйлсийг бүртгэсэн анхан шатны бүртгэл нийт 25 олдвор гэсэн байв. Сэргээн засварлалт, судалгаа шинжилгээний явцад 71 ширхэг эд өлгийн зүйл байгаа нь тодорхой болсон юм.

Монголын Үндэсний музейтэй хамтран 2017 оны 5 дугаар сарын 3-наас 6 дугаар сарын 6-ны өдрүүдэд "Хадан гэрийн соёл" үзэсгэлэнг зохион байгуулсан ба энэ үеэр мөн "Хадан гэрийн соёл" товхимлыг хэвлүүлэн олон нийтэд тараалаа.

Хадны оршуулгын авран хамгаалалтын ажлыг сэргээн засварлагч Б.Мягмарсүрэн, О.Оюунчимэг (эсгий, даавуу, арьсан эдлэл), Э.Батжартгал (мод, ширэн эдлэл), Н.Бат-Эрдэнэ (хатмал морь), Д.Нямдорж (металл эдийн найрлага тогтоо судалгаа), Үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн, археологич

Г.Бүрэнтөгс (бүртгэл, судалгаа) нарын бүрэлдэхүүнтэй баг амжилттай ажиллалаа.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сошиал өртөнчөөр эсгий дотортой, урт арьсан түрий, арьсан ултай, хоншоор хэсэгтээ бор цоохор сүлжмэл даавуун оруулгатай, боомоороо металл товруу чимэг бүхий суран оосортой гутлыг спортын "Адиdas" брэндийн гуталтай адитгасан мэдээлэл тархаж "Үзүүр гялан"-гийн олдворууд гадаад, дотоодод олны дунд хэдийнээ танил болсон билээ.

Он цагийн уртад өгөршиж хэврэгшсэн эртний түүхэн дурсгалт эд өлгийн зүйлсийг ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээхэд тэдгээрийг эрсдэх аюулгүй, агаарын чийг, дулаан, гэрэл гэрэлтүүлгийн тохиromжтой орчин нөхцөлд энэ хэвээр нь өнө удаан жил хадгалан, хамгаалах асуудал чухлаар тавигдаж байна.



"Хадан гэрийн соёл" үзэсгэлэн. 2017 он.

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

**О.Оюунчимэг**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч

### ШҮДЭН УУЛЫН ОЛДВОРЫН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

Үвс аймгийн Давст сумын Шүдэн уулын давсны орд уурхайд өнөөг хүртэл нутгийн иргэд хувиараа давс олзворлолт явуулдаг байна. 2017 оны 12 дугаар сарын 4-ний өдөр давс олзворлолтын явцад газрын гүнээс эртний хатмал шарил илэрснийг иргэд аймаг, орон нутгийн захиргаанд цаг алдалгүй мэдээлснээр хамгаалалтад авч, улмаар эрх бүхий байгууллагын шийдвэрээр ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Увс аймгийн музей, Соёлын өвийн үндэсний төв хамтран татан авчирч, сэргээн засвар, бэхжүүлэлтийн ажил хийгдсэн юм.

Үг олдворын цэвэрлэгээ, сэргээн засварлах ажлыг тус төвийн сэргээн засварлагч О.Оюунчимэг, Г.Ууганчимэг, Б.Мягмарсүрэн нар 2018 оны 6 дугаар сард хийж гүйцэтгэжээ. Үг олдворын материаллаг шинж чанарыг тодорхойлсоны үндсэн дээр хуучин төрх байдлыг хадгалж үлдээхийг зорин сэргээн засварлах ажлын арга зүй, төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Арьсан дээлтэй хүний занданшсан шарил нь давстай орчинд, өндөрлөг сэргүүн уур амьсгалтай ууланд хадгалагдаж байсан тул маш хуурай, шороо тоосны бохирдол ихтэй боловч маш сайн хадгалагджээ. Эсгий малгай, дээл хувцас, гутал бүрэн өмсгөлтэй, биеийн байрлал хөдөлгөөн сөхөрч суусан байдалтайгаар занданшсан байна. Хатмал шарилын доод хэсгээс тааран богц, төрөл бүрийн модон багаж, модны хугархай (хүрз, лантуу, гадас, ооль зэрэг хэлбэрийн модон багаж хэрэгсэл, модны хугархай) одсон байна.

Хатмал шарилыг хэмжихэд: өндөр- 101 см (толгойноос хөлийн үзүүр хүртэл), өргөн-77 см (баруун тохойноос зүүн гарын дунд хуруу хүртэл), доод хэсгийн өргөн-71 см (таазнаас хормой хүртэл), нийт жин- 24,66 кг байв.

Цэвэрлэгээний ажлын арга зүй: Хатмал занданшсан шарилыг



Хатмал шарилын цэвэрлэгээний явц.



(Тааран богц) Цэвэрлэгээний өмнө.



(Тааран богц) Цэвэрлэгээний дараа.

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ



(Хатмал шарил) Цэвэрлэгээний өмнө.



(Хатмал шарил) Цэвэрлэгээний дараа.



Хатмал шарилын дэргэдээс олдсон модон багажнууд.

“малгай, толгой, баруун гар хэсэг”, “гар, цээжин хэсэг”, “хөл хормойн хэсэг” гэсэн дарааллаар, 3-н удаагийн давтамжтай үелэх маягаар, хуурай аргаар шороо тоосны бохирдлыг цэвэрлэсэн. Зөөлөн багс, сойзоор үрэх, хулсан савх modoор наалдсан гадны бохирдлыг хөдөлгөх, тор тавьж тоос сорогчоор соруулах механик аргуудаар цэвэрлэгээг хийсэн. Олдворын зүүн гарын ядам хуруу, эрхий хурууны хумс хөндийрсөн байсныг илрүүлэн, салж унах эрслэлд орсон тус хэсгүүдийг арьсан цавуугаар нааж тогтоосон.

Шорооны бохирдлыг цэвэрлэсний дараа олдворын жин 20,06 кг болж багассан байна.

Тааран богц нь шарилын доод хэсгээс олдсон ба бор эрээн өнгөтэй, хоёр тийшээ харсан хоёр амтай уутны урт нь 75 см, хоёр амны хоорондох зай 22 см, маш их тоос шорооны бохирдолтой байсан ба цэвэрлэгээг тоос сорогчоор соруулж, мөн нэрмэл усаар 4-5 удаа зайлж цэвэрлэн, тасалгааны хэмд өөрөөр нь хатаасан. Уг ноосон нэхмэл богц цэвэрлэгээний өмнө урт- 172 см, өргөн- 57 см, цэвэрлэгээний дараа богшины урт-168 см болж, өргөн- 57 см хэвээр байв.

Олдвортой цуг ирсэн модон олдворуудад механик, хуурай цэвэрлэгээ хийсэн. Энэхүү олдворыг цаашид сэргүүн, хуурай тогтмол орчинд хадгалах шаардлагатай юм

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

**С.Даваадарь**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч

### АРХЕОЛОГИЙН ОРГАНИК ЭДЛЭЛД ТРЕХАЛОС САХАРЫН УУСМАЛ АШИГЛАХ НЬ

Монгол нутаг дахь археологийн малтлага, судалгаагаар илэрч буй олдворуудын дотор яаралтай хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын арга хэмжээ авахгүй бол устаж үгүй болох органик эдлэл тэр дундаа модон эдлэл маш их байна. Хадгалалт хамгаалалтын салбарт японы эрдэмтдийн нээсэн Трехалос (Trehalose) сахарын уусмалаар бэхжүүлэлт хийх аргачлал нь монголд хэрэглэгдэж эхэлж байна.

2017 онд Монголын Үндэсний музейн ахлах эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ц.Одбаатарын ахалсан хээрийн судалгааны багийн Орхон аймгийн Жаргалант сумын Айргийн гозгор хэмээх дурсгалт газар явуулсан археологийн малтлагын АГ7, АГ89 дугаартай Сяньби улсын үед холбогдох бунхант булшнаас гарсан олдворуудад хадгалалт, хамгаалалт сэргээн засварлалтыг Соёлын өвийн үндэсний төвийн Сэргээн засварлах газарт хийж гүйцэтгэлээ. Малтлагын талбайгаас гарсан олдворуудын баглаа боодлыг японы сав баглаа боодлын стандарт хэмжээнд нийцэхүүц хийж, олдворын чанарыг муутгалгүй, тухайн орчинд байсан чийгшлийг алдагдуулалгүй авчирсан нь үр дүнтэй байлаа.

АГ89 дугаартай бунхант булшнаас гарсан модон эдлэлүүд: а вс, жижиг хайрцааг, хүүхэлдэй, эмээлтэй морь, үхэр, чингэлэгтэй үхэр тэрэг, чихтэй аяга зэрэг олон хэсэг болон салж эвдэрсэн олдворуудад трехалос сахарын уусмалаар анх удаа бэхжүүлэлт хийллээ.

Археологийн модон эдлэлийн хадгалалт, хамгаалалтад дэлхийн олон улсууд полиэтилен гликолийн уусмал, спиртийн уусмал, сахарын уусмал, вакуумжуулж хөлдөөх зэрэг аргачлалуудыг өргөн хэрэглэж байна. Эдгээр аргууд нь өөрийн гэсэн онцлог дараалал, өндөр өртөг бүхий лабораторийн орчин шаардлаг. Одоогоор

дээрх аргуудаас хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа аргачлал бол полиэтилен гликолийн гэх мэт усанд уусдаг бодисуудын аргачлал юм. Полиэтилен гликолийн атом молекул нь 3800 масстай бөгөөд модон эдлэлтэй хамт олдох төмөр хадаас зэрэг металтай хамт химийн урвалд орж олдворыг цайруулах болон ялзруулах зэрэг дутагдалтай асуудлууд үүсгэж байна.

Тиймээс Японы эрдэмтдийн гаргаж авсан өөр нэгэн аргачлал нь сахарын уусмалын өөр нэгэн төрөл болох трехалос уусмал юм. Үг уусмалын атом молекул 380 масс буюу маш жижиг масстай учраас хаталттай модруу ороход хялбар байдаг. Мөн дигедри буюу маш хүчтэй талст үүсгэдэг онцлогтой. Үг сахар нь:

- Хүний биед хор нөлөөгүй,
- Энгийн хялбар ажиллагаатай,
- Хямд төсөр,
- Цэвэршүүлж дахин ашиглах боломжтой.

Дээр дурдсан полиэтилен гликолийн болон спиртийн уусмалын аргачлалууд нь уусмалдаа тааруулж олдворыг сэргээн засварлахыг шаардлаг бол трехалос сахарын уусмалыг олдвортоо тааруулж аргачлалаа өөрчилж болдог давуу талуудтай. Энэхүү бодис нь бусад бодистой харьцуулахад талст үүсгэдэг учраас гэрлийн хагас тусгал хүлээн авч олдворын гадаргууг гэрлийн нөлөөнөөс хамгаалах чадвартай. Трехалос нь 10 %-ийн ус агуулдаг ба усанд уусч уусмалын хэлбэрт орж модны гол бүтэц бүрэлдэхүүний хэсэг болох лигнин, хэмисэмиров, сэмировийн төвшинд очиж талст үүсгэж бэхжүүлдэг. Трехалос уусмалын бэхжүүлэтийн арга зүй гэдэг нь модонд агуулагдах усны тодорхой хэмжээг 60%-80%-ийн халуунд ууршуулан ус агуулж байгаа усны эзэлхүүний оронд солин оруулж

уурын төлвийг хөргөөж хатуу төлөвт шилжүүлж талст үүсгэх байдлаар бэхжүүлэхийг хэлдэг. Энэхүү талст нь 90%-ийн чийгшил хүртэл ууршихгүй, сэргүүн хуурай нөхцөл бат бөх чанараа алдаггүй онцлогтой.

Трехалос сахарын уусмалаар бэхжүүлэтийг этанолийн спирттэй хольж шууд шингээх, уусмалын аргаар бэхжүүлэлт хийх гэсэн 2 төрлийн аргачлааар хийдэг.

#### 1. Уусмалыг этанолийн спирттэй хольж шууд шингээх аргачлал:

Модон эдлэлд сахарыг шингээхэд анхаарах зүйл нь модны шинж чанар, бүтцийн гэмтэл зэргээс ихээхэн шалтгаална. Монгол орны археологийн модон эдлэл нь усны агууламж багатай байдал тул усанд хийхэд хөвдөг онцлогтой. Энэхүү онцлог нь сахарын шингэлтэд сэргээр нөлөөлөх талтай. Тухайн модон эдлэл усанд живдэг буюу усны агууламж өндөр байх үед сахарын уусмал нь модонд байх усиг түрж гарган тэрхүү зайнд шингэн орх боломжтой болдог. Гэвч усны агууламж багатай модны бүтцийн гэмтээс шалтгаалаад усанд хийхэд усны агууламж нэмэгдэх боловч модны бүрэлдэхүүнд байх лигнин задарч тухайн мод үйрч бутрах аюултай болдог. Ийм шинж чанартай олдворуудад 70% сахар, 30% ус, 10%этанолбайхаартооцож халуун усанд трехалос сахарыг найруулж олдворын гадаргуун нягтилийн массыг багасгаж модны гүнд уусмалыг шингээхийн тулд этанолийн 99%-ийн уусмал хийж 50%-60% дулаантай уусмалыг модны гадаргууд гуурсан шүршигчээр түрхэж бэхжүүлж хүйтэн салхин сэнсээр үлээлгэн хатаах ажиллагааг хийнэ. Олдвор анх ямар жинтэй байсан, уусмал түрхсэний дараах жин болоод хаталбүрэндүүсч, жинтогтворжих хүртэл өдөр бүр жинг үзэж хяналт

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ



Сахарын уусмалаар (Трехалос) бэхжүүлэлт хийгдсэн модон олдворууд.

тавина. Жин тогтвортсон үед олдворын гадаргууд наалдсан сахарын илүүдлийг усны халуун даралттай уураар үлээгч багажаар анхааралтай ажиллаж цэвэрлэснээр дуусгавар болно.

**2. Уусмалын аргаар бэхжүүлэлт хийх аргачлал:** Усны агууламж ихтэй бүтцийн гэмтэл багатай олдвор нь уусмалд байх боломжтой бөгөөд дээрхээс өөр аргаар бэхжүүлэлт хийнэ. Трехалос уусмал нь 70%-д ханасан уусмал болдог онцлогтой бөгөөд модон эдлэлийг сахарын бага хувиас дээд тал нь 70% хүртэлх уусмалд хийж болох бөгөөд сахарын уусалтад тохиорх дулаан тохицуулгачтай танк болон халаагч шүүгээнд байлгаж олдворт сахар нэвчин орж байгааг өдөр тутмын жин хэмжилтээр хянана. Жин тогтвортвол модонд шингэх уусмал ханасан байх тул уусмалын хувийг нэмж дээд хэмжээ буюу 70% хүртэлх уусмалд байлгаж жин тогтвортсон үед гаргаж хүйтэн сэнсэнд үлээлгэж хатаана. Хаталт явагдах үед жин багасах бөгөөд жин тогтвортсон үед дээр дурдсан аргаар цэвэрлэгээ хийж дуусгана.

Дээрх хоёр аргаар хийгдсэн хадгалалт, хамгаалалтын аргачлал нь Япон Улсын Нара их сургуулийн судлаач, доктор М.Оюунтулгын өмнө хийж байсан “Монголын тал хээрийн бүсээс илэрч буй чийгшилтэй орчны модон эдлэлийн онцлогт таарсан хадгалалт, хамгаалалт, бэхжүүлэлтийн арга зүй” судалгаан дээр тулгуурлан сахарын уусмалыг модны онцлогт тааруулан бэхжүүлэлтийн арга зүйг өөрчлөн хийж болох давуу талыг хэрэгжүүлсэн юм.

Японд трехалос сахарын уусмалыг модны хадгалалт хамгаалалтад ашиглахаас гадна даавуу, метал, чулуу, бусад материалд ашиглаж үр дүн нь сайн гарсан жишээнүүд байгаа тул манай оронд ч гэсэн энэ туршилагыг хэрэгжүүлж хадгалалт, хамгаалалтын судалгааг үргэлжлүүлэх зорилготой байна.

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

**Н.Жамбал**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч

### “ИХ БУРХАНТ” ЦОГЦОЛБОРЫН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ

**М**онгол Улсын Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны төлөвлөлтийн 7.1.2 дахь заалт, Ерөнхий сайдын 2012 оны 11 тоот захирамжийн дагуу Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дахь “Их Бурхант” чулуун бурханы цогцолбор дурсгалыг сэргээн засварлахад шаардлагатай түүх, архивын мэдээлэл хэрэглэгдэхүүн цуглуулах, зөвлөх үүрэгтэй Эрдмийн зөвлөлийг байгуулснаар уг цогцолборыг сэргээн засварлах нөр их үйслийг эхлүүлсэн юм.

1996-1997 онд Дорнод аймаг “Их бурхан” сан байгуулж, уг дурсгалыг сэргээн засварлахдаа мэргэжлийн бус хандаж дурсгалын чулуун гадаргуун бүх талбайг цементээр бүрж, тосон будгаар будсан нь дурсгалын түүх, соёл, урлаг гол зүй, шинжлэх ухааны үнэ цэнийг алдагдуулсан харамсалтай бөгөөд сургамжтай явдал болсон юм.

Дээр дурласан Үндэсний хөтөлбөрт заасны дагуу манай төвийн сэргээн засварлах хэлтсээс археологийн хүрээлэнтэй хамтран хээрийн судалгаа хийж, цуглагдсан

мэдээлэл, хэрэглэгдэхүүнийг үндэслэн дурсгалын эвдрэл гэмтлийг тодорхойлох, үнэлэлт өгөх, сэргээн засварлах арга зүй технологи, техник эдийн засгийн үндэслэл бүхий тооцоо судалгаа, сэргээн засварлах зураг, үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулж, улмаар 2012-2015 оны хооронд 4 жилийн хугацаанд уг цогцолборын сэргээн засварлалтын ажлыг хариуцан гүйцэтгэлээ.

2012 онд бид уг цогцолбор дурсгалыг бүрсэн цементэн бохирдлыг хуулж, цэвэрлэн сэргээн засварлалтыг хийж эхлүүлсэн ба буруу өрсөн дотор хэрмэн хананы өрлөгийг задлан дахин шинээр зөв болгон өрсөн, нөхөн сэргээн засварлалт хийх ижил төрлийн чулууг хайж судлан, зөөж аваачсан, Буйр нуурын дэргэд зөөгдөж хаягдсан 6 ширхэг Аюуш бурханыг төвдөө татан авчирч, дутуу хэсгүүдийг нь шинэ аргын чулуугаар нөхөн сэргээж, цогцолборт газраа байрлуулахаар бэлтгэсэн.

2013 онд “Их Бурхан” цогцолборын гол шүтээн

Жанрайсиг бурханы эх бие буюу лагшин, лагшингийн зарим дутуу хэсгүүд, мутар, мутрын барьцнууд, хөл, хормогч, хормогчны бүс, хормогчны үзүүр хэсэг, бурханы нүүр, бурханы толгойн гэрэл буюу ар хэсэгт байгалийн, засваргүй 800 ширхэг том хэмжээний элсэншэр, гварлит чулуунуудыг ашиглан сэргээн засварлах ажлыг гүйцэтгэсэн.

Бид энэхүү сэтгүүлийнхээ өмнөх 2012/1, 2013/1 дугааруудад тухайн онд хийгдсэн сэргээн засварлалтын ажлуудынхаа талаар нийтэлж байсан.

2014 онд өмнөх оны сэргээн засварлалтыг үргэлжлүүлэн Жанрайсиг бурханы нүүрэн хэсэг, мутар, мутрын барьцнууд, цээжин хэсгийн эрхин чимэг, хөл орчмын хадган чимэг, бурханы гэрэл бараан ногоон, улаан хүрэн чулуун дэвсгэрийг суулгах, нөхөн сэргээж, гүйцээсэн. Жанрайсиг бурханы хөл дор, мөргөлийн тавсан дээр сэргээн зассан биш Аюуш бурханыг зөв байрлуулсан, мөн тавсан дээрх Гонгор, Дүртэддагва бурханы хуучин уугуул чулуун хийц, шинээр хийсэн



Сэргээн засварлалтын өмнө. 2012 он.

## СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ



Сэргээн засварлалтын ажлын явц. 2013 он.

хийцүүдийг угсрах, уг бурхадын лагшин, хийц бүхий гадаргуугийн шинэ хээг цоохорлон хуучруулах, эрдэс будгийн суурь будалт ажил зэрэг сэргээн засварлалтуудыг хийж дуусгасан. 2013-2014 онд сэргээн засварлах ажил томоохон цар хүрээтэйгээр хийгджээ.

Улс орны хэмжээнд эдийн засгийн нөхцөл байдал хүндээрч, төсөв санхүүгийн байдал хумигдсан нь сэргээн засварлалтын ажилд нөлөөлж 2015 онд цөөн хүний бүрэлдэхүүнтэйгээр богино хугацаанд ажиллав. Энэ үеэр Жанрайсиг бурханы нүүрний зарим хэсгүүд тодруулбал хамрын хянга, хоёр нүдний хүүхэн хараа,

доод зовхины хацартай нийлэх хэсэг, нүдний хоёр захын төгсгөл хэсгийн чамархайтай нийлэх хэсэг, хамрын самсаа угалз дүрслэлтэй хэсгийн хацартай нийлэх хэсэг, хамрын үзүүр хэсэг, уруулын дээд хамартай залгах хүн хонхорхойн хэсэг зэрэг хийцүүдэд ус чийгэнд тэсвэрлэх чадвартай шар шавар, шохой, давсны холимог зуурмагаар хэлбэр форм гарган хийсэн ба B72 хамгаалалтын уусмалаар 2-4 см-ийн нэвчилттэйгээр 2 удаагийн давтамжтайгаар бэхжүүлэлт хийсэн. Улмаар гол бурханы нүүрний хийц бүхий дээрх хэсгүүдийн дутууг мөн байгалийн чулуугаар (шавар хэлбэр формыг

хэсэгчилэн ухаж аван оронд нь ) хийж гүйштгэсэн болно.

Дөрвөн жилийн хугацаанд “Их Бурхант” монументаль сүрлэг хэлбэрийн цогцолбор чулуун дурсгалын 80 орчим хувь нь технологийн дагуу сэргээн засварлагдсан ба цаашдаа ойрын жилд дурсгалын үлдсэн хэсгийн сэргээн засварлалтын ажлыг үргэлжлүүлэх, сэргээн засварлалтыг бүрэн дуусгах шаардлагатай байна.



Сэргээн засварлалтын ажлын явц. 2015 он.

## МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙ

**Δ.Нарантуяа**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх асуудал, хэрэгшээ нь юуны өмнө соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалахад чиглэгдэж байгаа бөгөөд цаашлаад үндэсний тусгаар тогтол, соёлын өв, уlamжлалыг авч үлдэх, сэргээх, ирээдүй хойчист уlamжлуулан үлдэх, нийгмийн ашиг тусын төлөө өргөнөөр ашиглан, түгээн дэлгэрүүлж, нийгэм хүний хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм.

Бүртгэл, мэдээллийн сан нь тавьсан зорилтод нийцүүлэн<sup>1</sup> зохион байгуулалттайгаар соёлын өвийг бүртгэн баримтжуулж мэдээлэл шуглуулах, сан бүрдүүлэх, шаталын дагуу бүртгэл, мэдээллийн санд бүртгэл, мэдээлмээ дамжуулж хүргэх, ашиглах, түгээх цогц үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү цогц үйл ажиллагааны хүрээнд дараах ажиллагаанууд шат, шатны Бүртгэл, мэдээллийн санд хийгдэж байх ёстой.


Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.5 дугаар зүйл, Сумын Соёлын төвийн үлгэрчилсэн дүрмийн 8 дугаар зүйл, 2.2.1 дүгээр зүйл, Соёлын ордны үлгэрчилсэн дүрмийн 1.7 дугаар зүйл, 2.2.1 дүгээр зүйлд тус тус соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх тухай Соёлын төвийн үүргийг заажээ.

Соёлын төвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийн байдлаас үзэхэд ихэнх газруудад соёлын биет ба биет бус өвийн бүртгэлүүд дутуу дулимаг хийгдэж, хадгалагдаж байна. Соёлын төвийн бүртгэл, мэдээллийн санд буй хөдлөх дурсгалт зүйлийн холбогдох бүртгэл нь ихэнхдээ ОНСТанхимын үзмэрийг бүртгэсэн "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл"-ээр хязгаарлагдаж байна.

Соёлын төвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийн

## ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ БА МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭЛТ

(Соёлын төвийн ажилтнуудад зөвлөмж)



хүрээнд санд цуглагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, холбогдох баримт бичиг материалыг архивлан хадгалах ажиллагаа дутуу, хийгдэхгүй явдал байсаар байна. Зөвхөн хөдлөх дурсгалт зүйл төдийгүй түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийн бүртгэлүүдийг төрөл зүйлээр нь ангилан, сэдвийн дагуу төрөлжүүлэн хадгаламжийн нэгж сан үүсгэн, дотоод товьёогжуулалт хийх, зориулалтын шүүгээ саванд хадгалах, цуглагдсан бүртгэлүүдийн бүрэн бүтэн байдлыг хангаж архивлан хадгалах ажиллагааг байнга зохион байгуулан сангийн бүрдлийг бүрдүүлж байх шаардлагатай.

Хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд Сүм, Дүүргийн бүртгэл, мэдээллийн санд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн холбогдолтой дараах бүртгэлүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 541 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан

"МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ"-ийн маягтын дагуу харьялах нутаг дэвсгэрийнхээ нийтийн болон хувийн өмчийн бүртгэл /мөн "RCH- Registration of Cultural Heritage" цахимд оруулан/; (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2.1);

- Орон нутаг сурталчилах танхимиын үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл буюу түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 4 жил тутмын улсын тооллогын бүртгэл, тайлан / цаасан болон "Register" цахимаар/ (мөн хуулийн 21.2.1; 21.2.4; 26 дугаар зүйл);
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн гэрэл зураг, дуу, дурс бичлэг; (мөн хуулийн 21.2.6; 21.2.7);
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн сэргээн засварлалт, судалгаа шинжилгээний ажлын тайлан (мөн хуулийн 21.2.2; 21.2.3);
- Тухайн орон нутаг сурталчлах

<sup>1</sup>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.1 дахь заалт "Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь соёлын өвийг эвдэрч гэмтсэн, устсан, мартагдсан тохиолдолд тэдгээрийг сэргээхэд шаардагдах бүрэн мэдээллийг агуулсан байвал зохино."

<sup>2</sup>Иргэний хуулийн 99.2 дахь заалт: Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна.

<sup>3</sup>Иргэний хуулийн 99.3 дахь заалт: Хувийн өмч нь иргэний болон дундын гэсэн хэлбэртэй байна.

танхимын үзмэр, эд өлгийг хувилсан, хэв загвараар нь бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, мерчандайзийн гэрээ байгуулсан бол холбогдох баримт бичиг (мөн хуулийн 53, 54, 55 дугаар зүйл);

- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хуучны данс бүртгэл ба бусад бүртгэл, мэдээлэл г.м Сайн хийгдсэн бүртгэл баримтжуулалт нь соёлын өвийг хадгалж хамгаалах хамгийн чухал алхам гэж олон улсын жишигт үздэг. Соёлын төв соёлын өвийн талаар мэргэшсэн ажилтны орон тоо байхгүй, ажил үүргийн хувьд давхар хариуцан ажиллаж байгаа нь гол бэрхшээл юм.

Манай улсын Иргэний хуулийн 99 дүгээр зүйлд өмчийг нийтийн<sup>2</sup> болон хувийн<sup>3</sup> гэж хуульчилсан байдаг. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөлийн хэлбэр харгалзахгүйгээр соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэдэг онцлогтой. Иймээс Соёлын төв нь ОНСТанхимаар хязгаарлагдахгүй харьялах нутаг

дэвсгэрийнхээ нийтийн болон хувийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг “Монголын Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” буюу RCH-ын програмаар бүртгэн, мэдээллийн санд бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэн баримтжуулахад бид энгийн зүйлсээс эхлэх ёстай. Тухайн эдийн угсаатны зүйн болон олон нийт нэрлэж заншсан нэр томъёог нэрлэж мэддэг, хийсэн материал /чулуу, даавуу, шил, металл г.м./ыг нь, хийсэн арга /оёсон, цутгасан, будсан, хэвлэсэн г.м./ыг нь, ямар төрөл /баримал, уран зураг, гар бичмэл г.м./ийн эд зүйл болохыг таньж тогтоон, өндөр, өргөн, урт, зузаан, жинг нь хэмжиж, уг зүйлийн хэлбэр төрх, өнгө, дүрс зэрэг нүдэнд харгадаж байгаа физик шинжийг оновчтой үгээр, үнэн зөв тодорхойлон бичиж, хэн хэзээ хийсэн, хэрэглэж байсан, одоо хаана хэрхэн ашиглагдаж байна зэрэг асуултад хариулагдахаар мэдээллийг

цууглувлан тэмдэглэн бичих явдал юм. Та үүнийг хийж байгаа бол түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн анхан шатны бүртгэлийг хийж чадаж байна гэсэн үг.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл хийхэд:

- Хариуцсан ажилтанг тогтворт суурьшилтай ажилуулах, бүртгэл хийх чадавхийг нь дээшлүүлэх, дадлагажуулах, соёлын өвийн талаар мэдлэгжүүлэх, мэргэшүүлэх;

- RCH болон Register бүртгэлийн програм суурилуулсан компьютер, хэвлэгч машин, хэмжилтийн төрөл бүрийн шугам, жин хэмжүүр, үзмэр, эд өлгийн зүйлийг баримтжуулах гэрэл зургийн аппарат хэрэгсэл, диктафон тоног төхөөрөмжөөр хангах, хангагдах, бүртгэл, мэдээллээ дамжуулах интернет сүлжээтэй байх,

- Бүртгэлийн програм, техник хэрэгслээ эзэмшиж, хэрэглэж чадлаг байх зэрэг зөвлөмжийг хүргүүлж байна.

### Ш.Энхтуяа

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын ерөнхий бүртгэл, мэдээллийн санч

## БАРИМТАТ ӨВИЙН ТУХАЙ

**Н**ҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллага ЮНЕСКО-гоос хүн төрөлхтний бүтээсэн соёлын өвийг хадгалах,

хамгаалахад чиглэгдсэн олон заавар, зөвлөмж, уриалга гаргаж хэрэгжүүлж ирсэн байдаг. Үүнд, “Соёлын биет бус өвийг өвийг

хамгаалах тухай конвенц” 2003, “Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” 1970, “Соёлын илэрхийлийн олон төрлийг хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай конвенц” 2005, “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц” 1972, “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг хамгаалах тухай Гаагийн конвенц” 1954, “Хулгайлсан эсвэл хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-ийн конвенц” зэрэг болно.

Соёлын биет болон биет бус



## МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙ

өвийн шинж чанарыг хослуулан агуулсан онцгой нэгэн өв бол бичиг үсгээр болон дүрс, дуу авиааны бичлэгийн арга хэлбэрээр баримтжуулан үзээсэн "Баримтат өв" юм. Энэхүү өв нь бусад бүх өвийн төрөл хэлбэрийн дотроос илүү тодорхой, дэлгэрэнгүй, асар их мэдээллийг багтаасан байдал учир хүн төрөлхтний дурсамж, ой санамжийг хадгалах, хойч үед өвлүүлэн эзэмшүүлэх, дэлхийн түүхийг илүү үнэн бодитойгоор гэрчлэн нотлоход юугаар ч орлуулшгүй бөгөөд үнэлж баршгүй ач холбогдолтой<sup>1</sup> ажээ.

Хүн төрөлхтний дурсамж, ой санамж болсон баримтад өвийг хамгаалах зорилгоор 1992 онд ЮНЕСКО-гоос "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийг эхлүүлсэн байна. Энэ хөтөлбөрийн гол зорилго бол баримтат өвийг олон улсын, бүсийн, үндэсний ач холбогдооор ялгаж олон улсын болон бүс нутгийн өвийн бүртгэлд бүртгэх, хадгалалтыг сайжруулах болон баримтат өвөө хамгаалах ухамсар ойлголтыг гишүүн орон, ард иргэдэд нэмэгдүүлэх, гишүүн орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, холбогдох төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх явдал юм. Баримтат өвд дараах зүйлсийг хамруулдаг.

Үүнд:

- Бичиг үсгээр хад чулуун дээр болон цаас бусад уламжлалт материал (арыс, шир, мод, модны холтос, хальс, үйс, навч, торго, бөс даавуу, төрөл бүрийн металл гэх зэрэг) дээр бичиж, сийлж, зурж, оёж хатгаж, барлаж, хэвлэж үлдээсэн бичгийн дурсгалууд,
- Марк, ил захидал, мөнгөн тэмдэгт зэрэг зураг болон бусад
- дүрслэлийг ашигласан хэвлэмэл дурсгалууд,
- Бүх төрлийн гэрэл зураг, гэрэл зургийн материалууд,
- Кино, дүрс, дуу авиааны бүх төрлийн бичлэг, механик, соронзон бичлэгийн хэрэгслүүд (фонограм, бичил ховилт болон туузан бичлэг, соронзон хуурцаг, диск, пянз), мэдээллийг харах (оптик)

хэрэгслүүд (дуу авиааны CD, CD-ROM, видео диск, оптик хуурцгууд)

- Электрон хэвлэл (дэлгэцээс буулгасан болон дэлгэцэнд байгаа), электрон бичлэг, мэдээллийг (E-mail, компьютерын файлууд) ордог.

Баримтат өвийг бүртгэх, хадгалж, хамгаалах, баримтад өвийн талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд үндэсний шалгуур үзүүлэлтийг тогтоох, ингэхдээ улсын болон орон нутгийн ач холбогдоор нь ялгаатай, үе шаттай байхаар боловсруулах нь зүйтэй юм.

Дэлхийн баримтат өв нь дор дурдсан шалгууруудыг нэг буюу хэд хэдэн шинжээр нотлогдсон байх ёстой байдал байна. Үүнд:

- Цаг хугацаа,
- Газар нутаг, орон зай,
- Хүмүүс, хүмүүсийн бүлэг, үндэстнүүдийн үйл хэргийг гэрчлэх,
- Өвийн агуулга, сэдэв,
- Өвийн хэлбэр загвар

Монголчууд баримтат өвийн арвин баялаг өв сантай. Өдгөө манай Монгол Улсын Үндэсний номын сангийн "Монгол судлал, гар бичмэл номын сан хөмрөг"-т 21 маянга орчим гар бичмэл, барын ном, "Төвөд номын сан хөмрөг"-т монгол, төвөд эрдэмтэн мэргэдийн бүтээсэн 1,5 сая орчим ном судар, "Дорно дахины ном, хэвлэлийн сан хөмрөг"-т 100 гаруй мянган, нийт гурван сая гаруй ховор чухал ном, судар хадгалагдаж байна.<sup>2</sup>

Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн "Дуун ухааны сан хөмрөг"-т тус

хүрээлэнгийн эрдэмтдийн 1950-1990 оны хооронд сурвалжлан шуглуулж бүрдүүлсэн аман зохиол болон нутгийн аялгууны материал бүхий 1200 орчим соронзон хальс, 1100 орчим тод үсгийн судар, эрдэмтдийн гараар бичсэн аман зохиол, нутгийн аялгууны хэрэглэгдэхүүн, тайлан бүхий 450 орчим хавтаст материал хадгалахад байдал.<sup>3</sup>

Монгол Улсын үндэсний архивын сан хөмрөгт Манжийн үеийн (1671-1911 оны) 223 хөмрөгийн 267 дансны 135961 хадгаламжийн нэгж, Богд хаант Монгол улсын үеийн (1911-1924 оны) 237 хөмрөгийн 243 дансны 29000 хадгаламжийн нэгж байдал ба эдгээр нь цаасан хэлбэрээр, давуун суурьтай, соронзон хальс, пянз, хуурцаг, диски дискет, CD, DVD, флаш болон бусад хэлбэрээр хадгалагдаж байна<sup>4</sup>.

Музейнүүдэд баримтат өвтэй холбоотой цуглуулга нэлээдгүй бий. 2012 оны улс, аймгийн музей сан хөмрөгийн улсын тоологоор register бүртгэлийн программаар орсон 34 музейн цуглуулгаас баримтат өвд хамаарах дурсгалыг шүүж гаргахад:

1. Баримт бичиг, аудио видео бичлэг 8144
2. Ном, хэвлэл, бичгийн хэрэгсэл 3334
3. Зоос, мөнгөн тэмдэгт 13937
4. Гэрэл зураг 31210
5. Бэлгэдэл, таних тэмдгийн холбогдолтой эд зүйл 6065
6. Бурханы зураг 9152 ширхэг байна гэсэн дүн гарлаа.<sup>6</sup>

Дэлхийн баримтат өвийн жагсаалтад Монгол Улсаас 6 өв бүртгэгдсэн. 2011 оны 5



"Алтан товч".

## МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙ



“Монгол шунхан данжуур”.



“Мэргэд гаражын орон”.

дугаар сард Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Манчестер хотноо болсон Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Олон улсын зөвлөлдөх хорооны ээлжит 10 дугаар бага хураар 80 гаруй баримтат өвийн материал хэлэлцсэнээс 45 хосгүй үнэт өвийг Дэлхийн баримтат өвийн жагсаалтад бүртгэсний дотор Монгол Улсаас дэвшүүлсэн Лувсанданзангийн “Алтан товч”

-Ази Номхон далайн бүс нутгийн баримтат өвийн жагсаалтад, “Монгол шунхан данжуур” -Олон улсын баримтат өвийн жагсаалтад орсон.<sup>6</sup> Үүний дараа 2013 онд “Есөн Эрдэнийн Ганжуур” -Олон улсын баримтат өвийн жагсаалтад; 2014 онд “Сахиусан Дара Эх” -Ази Номхон далайн бүс нутгийн баримтат өвийн жагсаалтад; 2016 онд “Мэргэд гаражын орон” толь бичиг- Ази Номхон далайн

бүс нутгийн баримтат өвийн жагсаалтад; 2017 онд “Данжуурын гэрэлт хөшөө”-г Олон улсын жагсаалтад дагалдах баримтат өвөөр тус тус бүртгэсэн байна.

Баримтат өвийн олон улсын болон бүсийн бүртгэлийн жагсаалтанд өнөөдрийн байдлаар нийт 100 гаруй улсын 300 гаруй баримтат өв бүртгэгдээд байна.<sup>7</sup>

Монгол Улсын Засгийн газраас баримтат өвөө хамгаалах зорилгоор 2014 онд “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр” батлан гаргасан байдаг. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд соёлын баримтат өвийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, соёлын баримтат өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, Соёлын баримтат өвийг сэргээн засварлах, соёлын баримтат өвийг судалгааны эргэлтэд оруулах, сурталчлах ажлыг хэрэгжүүлэх зорилт тавьж, уг зорилтоо 2015-2017 он, 2018-2022 онуудад үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гэвч энэхүү хөтөлбөр санхүүжилт байхгүй, судалгаа сурталчилгааны дорвийт ажил зохион байгуулаагүй зэргээс тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Хүн төрөлхтний дурсамжийн нэгээхэн хэсэг болсон баримтат өв хувь хүн, айл өрх, байгууллага бүрд хадгалагдсаар байгаа нь дамжиггүй. Энэхүү өвөө бүртгүүлэх, судлах, сурталчлах, хадгалах хамгаалах нь бүх нийтийн үйлс, соёлын ажилтнуудын үүрэг билээ. Та өөртөө, байгууллагадаа хадгалагдаж байгаа баримтат өвөө бүртгүүлэх [/www.nationalheritage.mn/Doceritage/Index](http://www.nationalheritage.mn/Doceritage/Index), улмаар судалгааны эргэлтэд оруулах, сурталчлан таниулах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах үйлсэд нэгдэшгээе.

<sup>1</sup>Ц.Жаргалсайхан. Соёлын лавлах товчоон. Уб.,2015 он, 235-р хуудас

<sup>2</sup>“Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр” Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 238 дугаар тогтооолоор батлагдсан.

<sup>3</sup>“Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр” Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 238 дугаар тогтооолор батлагдсан.

<sup>4</sup>Архивын ерөнхий газар. Төрийн архивын нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалтын ажлын арга зүй, зохион байгуулалт. Уб., 2015 он, 12-р хуудас

<sup>5</sup>Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан. 2012-2014 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын register программын дүнгээс

<sup>6</sup>У.Сайнбаяр. Монголын ховор ном, судар дэлхийн баримтат өвийн жагсаалтад бүртгэгдлээ. Соёлын өвийн мэдээ, мэдээлэл. Уб., 2011., N5, 35 хуудас

<sup>7</sup><http://www.unesco.mn/p/133>

## МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙ

**Ц.Цолмон**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийг авран хамгаалах газрын  
Дэлхийн өвийн дурсгал хариусан мэргэжилтэн

**С**оёлын өвийн үндэсний төв соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт, судалгааны чиглэлээр 2014-2018 онд ЮНЕСКО, Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт хамгаалалтын хүрээлэн, ЮНЕСКО-гийн итгэмжит байгууллага БНХАУ-д төvtэй Соёлын биет бус өвийн олон улсын сургалтын төв, Америкийн Монгол Судлалын төв зэрэг байгууллагуудтай хамтран дараах сургалтуудыг амжилттай зохион байгуулаад байна.

### Соёлын биет бус өвийн чиглэлээр:

Японы Итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр ЮНЕСКО-той хамтран 2012-2016 онд өвлөн уламжлагч, мэргэжлийн соёл, урлагийн байгууллага, орон нутгийн соёлын ажилтан наарт зориулан “Соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалт, шавь сургалт болон чадавхи бэхжүүлэх нь” сэдвийн хүрээнд:

- 2012 онд “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцийн үндсэн зарчим ба хэрэгжилт”,

- 2013 онд “Хамт ононд түшиглэсэн соёлын биет бус өвийн бүртгэн баримтжуулалт”,

- 2015 онд “ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх хэрэглэгдэхүүнийг боловсруулах”,

- 2016 онд “Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын

## СОЁЛЫН ӨВИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ-МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН СУРГАЛТУУД (2014-2018)



төлөвлөгөө”,

- 2016 онд “Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулалтыг цахим хэлбэрт шилжүүлэх нь” 5 удаагийн цуврал сургалтыг зохион байгуулсан.

Үндэсний хэмжээнд зохион байгуулсан дээрх цуврал 5 сургалтын хүрээг өргөтгөн, анхан шатны нэгж байгууллагуудын боловсон хүчиний мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 15 аймгийн Боловсрол, соёлын газартай хамтран нийт 244 сумдын соёлын төвийн ажилтнуудыг хамруулан салбар сургалтуудыг зохион байгуулсан.

**“ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцийн хэрэгжилтэнд хэвлэл,**

### мэдээллийн байгууллагуудын оруулах үүрэг, оролцоо” сэдэвт сургалт

Мөн Ази-Номхон Далайн бүсийн хэмжээнд анх удаагаа “ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцийн хэрэгжилтэнд хэвлэл, мэдээллийн байгууллагуудын оруулах үүрэг, оролцоо” сэдэвт сургалтыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, “Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны Зөвлөл”, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс хамтран ЮНЕСКО-гийн итгэмжит байгууллага болох БНХАУ-д төvtэй Соёлын биет бус өвийн олон улсын сургалтын төв (CRIHAP)-ийн дэмжлэгтэйгээр 2017 оны 9 дүгээр сарын 11-нээс 15-ны өдрүүдээд зохион байгуулсан. Сургалтыг Соёлын өвийн үндэсний төв, CRIHAP, Монголын сэтгүүлчийн нэгдсэн эвлэлийн сургач багш нар, ЮНЕСКО-гийн итгэмжит сургач багш, мэргэжилтүүд болох Александра Денес болон Рахул Госвами нар Улаанбаатар хотын болон 21 аймгийн хэвлэл, мэдээллийн байгууллагын 40 гаруй ажилтнуудад зохион явуулсан. Сургалтанд оролцогчид улс орны хэмжээнд “Соёлын биет бус өвийг хамгаалахад сэтгүүлчид хамтдаа”



## МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙ



нэртэй нэгдсэн сүлжээг үүсгэж, соёлын өвийн сэтгүүл зүй, тэр дундаа Соёлын биет бус өвийн сэтгүүл зүйг хөгжүүлэх анхны алхмыг уг сургалтын үр дүна хийсэн юм.

### **Соёлын өвийг сэргээн засварлах чиглэлээр:**

### **“Даавуу, зөөлөн эдлэлийг гэмтэхээс урьдчилан сэргийлэх нь” сургалт**

Соёлын өвийн төв, Богд хааны ордон музей, Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт хамгаалалтын хүрээлэн хамтран “Даавуу, зөөлөн эдлэлийг гэмтэхээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг 2014 оны 02 дугаар сарын 24-нөөс 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. Монгол Улсад орчин цагийн музей үүсгэн байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулагдсан энэхүү сургалтанд Улаанбаатар хотын 10 музейн сан хөмрөгч, үзмэр харагч, Соёлын өвийн төвийн даавуу зөөлөн эдлэлийн сэргээн засварлагч зэрэг 25 хүн оролцсон байна. Сургалтыг Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт хамгаалалтын хүрээлэнгийн захирал, профессор Габриала Крист, тус хүрээлэнгийн багш, судлаач Таня Киммел, Бритта Швенк нар удирдан явуулсан.

### **“Соёлын өв, археологи, палентологийн дурсгалыг 3-н**

### **хэмжээст байдлаар баримтжуулах нь” богино хэмжээний сургалт**

Соёлын өвийн үндэсний төв, Америкийн Монгол Судалын төв хамтран энэхүү сургалтыг 2014 оны 06 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Палеонтологи, геологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Монгол Цэргийн музейн ажилтнууд оролцов. Сургалтаар археологи, палеонтологийн дурсгалыг 3-н хэмжээст байдлаар бүртгэн баримтжуулах арга зүйн зөвлөгөө болон дадлага ажлыг АНУ-ын судлаач Бенжамин Миэдиртэй хамтран тус төвийн програмист Ж.Даваацэрэн, мэргэжилтэн П.Чинбат, Ц.Цолмон нар удирдан явуулсан байна.

### **“Шороон Бумбагарын бүнхант булашны ханын зургийг сэргээн засварлах, хадгалж**



### **хамгаалах нь” сэдэвт ЮНЕСКО-гийн сургалт**

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, ЮНЕСКО-гийн Бээжин дэх Төлөөлөгчийн газар, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс хамтран ЮНЕСКО, Монакогийн Итгэлцлийн Сангийн дэмжлэгтэйгээр “Майхан уулын Шороон Бумбагар археологийн дурсгалыг хадгалах, хамгаалах, тогтвортой менежмент бий болгоход боловсон хүчнийг чадавхжуулах, олон нийтийн ухамсыг нэмэгдүүлэх” төслийг 2014-2019 онд амжилттай хэрэгжүүллээ. Тус төслийн хүрээнд ханын зургийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт, инженер-геологи, орчны судалгааны чиглэлээр ЮНЕСКО-гийн итгэмжлэгдсэн мэргэжилтнүүд Лужан Лансфорд Родолфо, Клаудио Марготтини, Алессандро Боназза, Маурицио Гуэрра нар Монгол Улсад хүрэлзэн ирж Шороон Бумбагарын хадгалалт, хамгаалалттай холбоотой дараах цуврал сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

1. “Ханын зургийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд үнэлгээ хийх болон тогтвржуулахад инженер-геологийн арга зүйг ашиглах” сургалтыг 2015 оны 10 дугаар сарын 19-өөс 11 дүгээр сарын 6 өдрүүдэд,

2. “Соёлын өв, ханын зургийн хадгалалт хамгаалалт, засварт

## МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙ

гидрогоеологийн үзүүлэх нөлөө" сургалт 2016 оны 9 дүгээр сарын 5-17 өдрүүдэд,

3. "Ханын зургийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт болон соёлын өвд үзүүлэх цаг уурын нөлөө" сургалт 2017 оны 4 дүгээр сарын 2-16 өдрүүдэд,

4. "Орон нутгийн иргэдийн соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх нь" сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 17-нд тус тус зохион байгуулсан.

### **"Чулуун соёлын өвийн хадгалалт, хамгаалалт" сургалт**

Мөн тус төв 2016 оноос эхлэн Австри улсын Венийн Хэрэглээний Урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнтэй хамтран "Чулуун соёлын өвийн хадгалалт, хамгаалалт" харилцан туршлага солишлох сургалтыг 2 жил дараалан Улаанбаатар хот болон Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Их Хөшөөтийн цогцолбор дурсгалыг түшиглэн зохион байгуулав. Сургалтад ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, СУИС-ийн Дүрслэх, дизайн урлагийн сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль, Төв болон Дундговь аймгийн музей зэрэг байгууллагуудын судлаачид, хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргжилтнүүд оролцлоо.



**Б.Алтансүх**

“Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл” ТББ-ын тэргүүн

## “МОНГОЛ ЦООЖНЫ ГАЙХАМШИГ” ТӨСЛИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ

**С**оёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл” ТББ нь соёлын өвийг хадгалж хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилготой төрийн бус байгууллага юм. Тус байгууллагаас 2018 онд монгол цоожийг судлах, өв уламжлалыг олон нийтэд таниulan сурталчлах зорилгоор “Монгол цоожны гайхамшиг” төслийг санаачлан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Соёл, урлаг хөгжүүлэх сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүллээ.

Монголчуудын соёлын өвийг уламжлан хадгалах, сэргээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээний үр дүнд иргэд ялангуяа залуучуудын өв уламжлалын талаар мэдлэг өсөж, ёс заншлаа дагах, сэргээх эрмэлзэлтэй болж байна. Өнөө цагийн аж төрөх ёсны аясаар бүх юм шинэчлэгдэж, орчин үеийн арга технолог бидэнд илүү ая тухтай амьдрах боломж өгч байгаа учраас хуучин эд зүйлс хэрэглээнээс гарч орхигдон мартагдаж байна.

Үндэсний уралыг илтгэсэн, одоо улам цөөрсөөр байгаа нэг

төрлийн өвийн талаар улс, аймгийн музейн цуглувалгыг түшиглэн судлаж, олон нийтэд хүртээхийг зорьсон нь “Монгол цоож” юм. Монгол цоож нэрээр түгсэн энэ цомхон зохиомжит бүтээлийг хэрэглэж үзээгүй айл гэр, хүн байхгүй биз ээ.

Бид өдөр тутам эд хөрөнгө, оюуны бүтээлээ хадгалуулж, хамгаалуулж байдаг хамгийн найдвартай итгэлтэй түвш бол түгжээ цоож билээ.

Уран дарханы ур ухаанаар бүтсэн, монголын гэсэн энгийн төв, өөрийн ур хийшиг тогтоож чадсан, өргөн олон нийтээр хэрэглэж байсан цоож бол монголчуудын уламжлалт соёлын өв юм. Төмрийн дархан цоож, илүүр, тамга, хутга шөвөг зэрэг байнгын хэрэгцээтэй эд зүйлийг хийхээс гадна ур чадвараа үзүүлж, хатуу төмрийг уяруулан янз бүрээр урлаж байв. Тоо, үсгэн кодтой, 12 жилийн амьтны дүрстэй түлхүүртэй, олон өргөстэй, мөнгө, гууль, зэсээр бүтээсэн, хээлж чимсэн зэрэг гайхамшигтай урласан цоожнууд манай музейнүүдийн сан хөмрөгт болон хувийн цуглувулгад

хадгалагдаж байна.

“Монгол цоожны гайхамшиг” төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж олны хүртээл болгоод байна. Үүнд:

- Уран дархчуудыг тодруулах судалгаа:** Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн, улс, аймгийн музейнүүдэд байгаа монгол цоож, түүнийг бүтээсэн уран дархчуудын талаар судалгаа хийж, холбогдох мэдээллийг музей болон Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэн өглөө.
- 3D анимешн:** Нэг түлхүүртэй энгийн болон гурван түлхүүртэй ярвигтай бүтэц бүхий монгол цоожны дотоод бүтэц, оньс углуургын ажиллах зарчмыг харуулсан 3D анимешн хийж Youtube видео платформ дээр байрлуулан олон нийтэд дэлгэн үзүүлж байна.
- Монгол цоожны 3D анимешн үзэх холбоос: [//mongoltsooj.mongoluv.mn/Video](http://mongoltsooj.mongoluv.mn/)

[www.mongoltsooj.mongoluv.mn](http://www.mongoltsooj.mongoluv.mn) веб сайт: Төслийн үр дүнд бий болсон монгол цоожны цахим мэдээллийн санг [www.mongoltsooj.mongoluv.mn](http://www.mongoltsooj.mongoluv.mn) веб сайтад байрлуулж олон нийтэд нээлттэй сурталчилж байна. Энэхүү веб сайтаас талаар дараах мэдээллийг авах боломжтой.

1. Дэлхийн цоожны түүх
2. Монгол цоожны тухай
3. Монгол цоожны бүтэц
4. Уран дархчуудын мэдээлэл
5. Монгол цоожны гэрэл зураг
6. Цоожны тухай оньсого
7. 3D анимешн
8. “Монгол цоожны гайхамшиг” төслийн тухай
9. “Монгол цоож - Мартагдашгүй өв” үзэсгэлэнгийн таницуулга

4. “Монгол цоож - Мартагдашгүй өв” үзэсгэлэн: Уг




“Монгол цоожны гайхамшиг” үзэсгэлэн.

## МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙ

төслийн хүрээнд "Монгол цоож - Мартагдашгүй өв" үзэсгэлэнг 2018 оны 12 дугаар сарын 19-25-ны өдрүүдээр Монголын театрны музейд амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэнд Р.Отгонбаатарын хувийн цуглуулга дахь 150 орчим ховор нандин монгол цоож биетээр тавигдсанаас гадна улс, аймгийн музейн шилдэг цоожнуудын гэрэл зураг, 3D принтерээр хэвлэсэн гурван түлхүүртэй монгол цоожны загвар болон монгол цоожны дотоод бүтцийг харуулсан 3D анимешн зэргийг дэлгэн үзүүлсэн. Энэхүү үзэсгэлэнгийн шинэлэг тал нь хуучны өв соёлыг орчин үеийн технологийн шийдэлтэй хослуулан үзүүлсэн явдал байв.

Энэхүү төсөл соёлын өвийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгжиж, тодорхой үр



3D принтерээр хэвлэсэн 3 түлхүүртэй монгол цоож

дүнд хүрч байгаа олон ажлуудын нэгэн сайн жишээ юм. Цаашид ч соёлын өвийг хамгаалах тал дээр төрийн, төрийн бус байгууллага болон ард иргэдийн хамтын ажиллагаа улам өргөжин тэлнэ хэмээн бид итгэж байна.

**Ц.Жаргалсайхан**

Соёлын өвийн үндэсний төв. Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч

## МАРТАГДАЖ БУЙ ӨВ- ЦАХИУР БҮҮ ХИЙХ ТЕХНОЛОГИ

**Н**үүдэлчин монголчууд эртнээс бүхэн бичил үйлдвэр, хүн бүхэн үйл мэтгэгч, дархан, мужаан болдог нь өвөрмөц авьяас, басхүү сонирхолтой зан заншил юм. Энэхүү авьяас чадвар олон зуун жил туршлагдан батлагдаж баяжин, өвлөн уламжлагдаж ирсэн.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 03 сарын 16-ний өдрийн 84 дүгээр тушаалаар батлагдсан Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай Үндэсний бүртгэлийн "Ардын гар урлал" айд багтсан нэг өв бол "Цахиур бүү хийх технологи" юм.

Ардын гар урлал, аж ахуй эдийн уламжлалт ухааны нэг-уран дархан, мужааны урлалын жишээ энэхүү өв нь өнөө цагт урлах арга ухаан нь мартагдаж байгаа юм.

Монгол дарханы үр ухаан, монгол анчин, цэрэг дайчны авхаалж самбаа, цэц мэргэний гэрч болсон, бялтгүй, цахиураар гал авалшах энэхүү бүү нь XVI-XIX зууны үед монголчуудын хэрэглэж байсан галт зэвсгийн анхны хэлбэрийн нэг.

Цахиур[1], замаг[2], гол төмөр[3], сүмбэ[4] зэрэг хийц хэсгүүд тэрчлэн дарь[5], сум[6], уул[7] тэдгээрийг агуулж хадгалах бортого[8] зэргээс бүрдэнэ. Цахиур бууны хот цэнэг, дагалдах хэрэгсэлд Чижкүүр (чихний дарь няцүүр), Сумны хор (гэр), Хорголжин сум, Сумны шаалтуур, Даринь хот (сав), Шэнэг (дарь хэмжкүүр), Тослуур зэрэг орно.

[Б.Амгалан.Баруун монголчуудын эдийн соёлын дурсгалт зүйлс. УБ.2010.x.165] Энэхүү зэвсэг цахиураас гарах очны үсрэлтээр дарь авалцаж буудах зарчимд тулгуурлан зохиогджээ.

Жишээ болгон Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошуу, өнөөгийн Өвөрхангай аймгийн Хужирт сумын харьяат "Бууч" хэмээх Цэрэндоржийн "Мэргэн тусгالت" хэмээх цахиур бууг ажигласан тэмдэглэл [Ц.Жаргалсайхан. Тэмдэглэл. ӨВ.1996. гар бичмэл]-ээсээ сонирхуулбал: Хот шахаг бүрэн. Пооз (хонгио) хөдсөн хүзүүгээр холбогдсон оосор бүхий модон

## ТАНИН МЭДЭХҮЙ, МЭДЭЭЛЛИЙН БУЛАН

бөглөөтэй. Шаантаг-Энэ мод бол тугалган сумыг ам руу нь хийгээд бууны гол руу шахаж оруулдаг. Үүний дараа бууны хүйны гол төмрийн өөхий доогуур орсон нүхэнд сүмбэ байна. Үүгээр сумыг дарьтай хамт шахан чихний дарьны цоорхой буюу шурганд туталт шахаж өгнө. Сүмны сав хэмээх булигааран сав хажуудаа хуруу дарам цоорхойтой байна. Таглаа ба хоёр сэнжийг холбосон гогцоо бүхий тослуурын сав байна. Тослуурын саванд тарвагны бөөрний өөх, хонины ноос хялгас унгастай хамт байдаг. Зэв-Дундаа дөрвөлжин нүхтэй, тэр нүхээр нь бууны бөгсийг эрэгдэн түгжих шургийг чангалах, сүмлах үүрэгтэй. Нөгөө талаар хөрөө ирмэгээр нь замагны нариаманд[9] байгаа цахиурыг хэтэндэ тохируулан ирмэглэх үүрэгтэй. Бэлтгэл түрийвчин саванд сумны хар тугалга, сумны хэв, дарь мэтийн нөөц хэрэглэлүүд байна.

Энэхүү цахиур буу нь 1.гол

замагны дээд, доод нарим, замагны шилний гогцоо, наримны тархи эрэг, цахиур, өшгөлбөр, замагны шилбэ ба шаант, шаант-өшгөлбөр холбосон нугасан эрэг, замагны сойлт, сойлтын хацаа, замагны хэт ба хэтний эрэг, б-Хүй-гол төмрийг суулгах гэрсэнт[10] хэсэг-замаг ангийг суулгах хэсэг ба шураг бэхлээ, мөрөвлөх хэсэг буюу Сүүл. Гэрсэнтэй холбосон хөл-гэрсэнтэй холбох тэвнэ. Их бага 2 тушаа-шийрлэхэд гулгахгүй байхад зориулсан шийрний хумс.

Цахиур бууны хөлийг гол төлөв яргай зэрэг уян модоор хийдэг ба хумсыг ихэвчлэн ооны эврээр хийдэг заншилтай байжээ. Цахиур бууг хийхэд ардын гар урлал, дархан, мужааны урлаг, зан үйл холбоотой бөгөөд цахиур бууны дарь хийх, буугаа гаалах[11] аргыг мөн жишээ болгон тэмдэглэвэл: Бууны дарь хийх арга нутаг бүрд адилгүй. Тухайлбал: Баруун халхад нуураас шүү авч хүхэртэй хольж хийдэг, хүхрийг нь бага, шүүг нь

зэрэг цутгаж болох хэвэнд тугалга хайлуулан хийж, хэрэв үнэг, хярс, туулай мэтийн жижиг амьтныг буудах бол жижиг хэвэнд цутгадаг байжээ.[БНМАУ-ын Угсаатны зүй.1.УБ. 1987.х.83] Бууны овоо хараа гэмтэх, гол гулзайх, зэврэх мэт эдэлгээнээс болж онохoo байхад цэвэрлэх, гэмтсэн хэсгийг нь анчид дархчууд засч байснаас гадна шүтлэг бэлэгдлийн чанартай зан үйл хийдэг байснаас үзэхэд цахиур буу, түүнийг урлах арга, технологи нь гар урлал, ан ав, ардын мэдлэг ухаан, зан үйтэй холбоотой, судлахад сонирхолтой сэдэв юм.

### Тайлбар:

1. Цахиур- гал гардаг нэгэн зүйл хатуу чулуу.
2. Замаг- бууны сумыг гол төмрийн тархнаарт оруулах, хонгиог татах гаргах, сумны бялтыг цохиж тэсэргэх хэрэгсэл, бууг цэнэглэх эд анги.
3. Гол төмөр- сумыг чиглүүлэх болон хол ойрын тусгалд үүрэгтэй хөндий төмөр. Ардын урлаачид төмрийг өөрсдийн уран бүтээлд өргөн ашиглаж байсан бөгөөд тэд голдуу ахуйн хэрэгшээний зүйлс: тулга, цоож, түлхүүр, цуурга, буу зэрэг гэр ахуйн зүйлээс эхлээд хөдөлмөрийн багаж зэвсгүүд, мал аж ахуйтай холбогдох зүйлийг хийдэг байжээ. Харин гоёл чимэглэл, бурхан шашны зүйлд дан хар төмөр нэг их хэрэглэж байсангүй.
4. Сүмбэ- гол төмрийг нударч цэвэрлэх хэрэгсэл (Монгол хэлний их тайлбар толь)
5. Дарь- галт зэвсгийн цэнэг хийдэг, асах, тэсрэх бодис
6. Сум-төмөрлөг, хорголжоор хийсэн, шовгор эсвэл мухар үзүүртэй хойноо бялт агуулсан буунд хийж буудах зүйл.
7. Уул- Шагаан уул цэшгийг хатааж, дарь авалцахад үүсгүүр болгон хэрэглэнэ.
8. Бортого- жижигхэн, ухмал модон сав.
9. Замагны нариам- замгийн хөндий
10. Гэрсэн- ховил
11. Гаалах- сүмлах



Цахиур буу.

төмөр, 2.хүй-гэсэн хоёр үндсэн хэсгээс бүтнэ, 3. 3-4ш бүслүүр 4. Гол төмрийн шураг, шурагны нугас, эрэг 5. Замаг-замагны эд анги нь

арай их хийж модны нүүрсийг тогоонд 5-9 дахин халааж байгаад хатаадаг аргатай байсан. Цахиур бууны сумыг хийхдээ олон сүм нэг

## BRIEF IN ENGLISH

M.Tsetsenbileg

Head of the Department for Cultural Heritage Registration and Research

### **Establishment of the National Center for Cultural Heritage**

By the Government Decree №239 of 23rd August 2017, the National Center for Cultural Heritage was established with the renewed structure and operational directives.

This publication provides a view of the legal act and related documents.

### **Inventorying of Immovable Historical and Cultural Monuments-2015**

In the framework of implementation of the Law on Protection of the Cultural Heritage, by the Decree №/63 of the Minister of the Culture, Sports and Tourism (former title) of 2014, the national inventory of the immovable historical and cultural properties was conducted from 1st of May, 2015 to 1st of October, for 6 months.

### **Protection and Preservation of the World Heritage the Great Burkhan Khaldun Mountain and its surrounding sacred landscape**

The nomination "Great Burkhan Khaldun Mountain and its surrounding sacred landscape" was inscribed in the cultural heritage category at the 39th World Heritage Committee meeting in Bonn, Germany, on 28th June 2015.

The article introduces the World Heritage property and provides a brief view of its protection and preservation management.

### **Introduction to the "Stone Cultural Heritage" National Program**

Stone monuments occupy a big part of the immovable cultural heritage in Mongolia, in particular, most of the archeological findings consist of stone objects and monuments. Therefore, issues of their protection and preservation are big in recent years.

The Ministry of Education, Culture, Science and Sports has developed and started implementing the "Stone Cultural Heritage" program in 2019-2024.

### **Risk Management of Historical and Cultural Immovable Monuments**

The National Center for Cultural Heritage has researched identifying the immovable cultural heritages at the "high risk" zones through 2015-2017 and developed the risk map on immovable cultural heritage in Mongolia. For more details, please take a look at the article on Page 13.

### **"Protection and preservation of Petroglyphs of the Mongolian Altai" field research and inventorying**

The National Center for Cultural Heritage is implementing series of activities on protection and preservation of the petroglyphs of Mongolian Altai by raising awareness of the general public through promotion on social media, providing cultural heritage education to local communities. In the framework of these activities, for 2 years, filed researches were conducted in cooperation with the Bayan-Ulgii province museum.

### **International partnership in the field of 3D documentation of the Architectural monuments**

In 2015, the National Center for Cultural Heritage under the Ministry of Education, Culture, Science, and Sports of Mongolia has signed Memorandum of Understanding on "3D Documentation, Digitization of Historical and Cultural Immovable Monuments, Temples and Monasteries, Architectural Monuments in Mongolia, and Capacity-Building of Professionals in the Cultural Heritage Filed" with the National Research Institute of Cultural Heritage of Republic of Korea.

### **International Partnership on the 3D Documentation of the Cultural Heritage**

To achieve more efficient documentation of cultural heritage, since 2008, the National Center for Cultural Heritage is exploiting the 3D laser scanning equipment on cultural heritage artifacts and immovable objects. For more details, please refer to the article.

### **Virtual Museum**

Open Laboratory of Computer Graphics, Multimedia Researches of the Mongolian National University in cooperation with the Fine Arts Museum of Zanabazar implemented documentation project on the digitization of exceptionally valuable works by the Undur Geegen Zanabazar, with a 3D laser scanner, in 2017-2018.

### **Mongolian Intangible Cultural Heritage inscribed in the UNESCO Lists**

Since the ratification of the UNESCO 2003 Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage in 2005, Mongolia has inscribed 14 intangible cultural heritage elements in Representative List of the Intangible Cultural Heritage of Humanity and List of Intangible Cultural Heritage in Need of Urgent Safeguarding. For more details, refer to the article.

### **"Nomadic Mongolia" Intangible Cultural Heritage Festival-2018**

The "Nomadic Mongolia" Intangible Cultural Heritage Festival-2018 was successfully organized on 10-12 August 2018. The festival was organized according to the principles of the UNESCO's 2003 Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage, involving practitioners of intangible cultural heritage elements in the 5 domains, from 21 provinces and 6 districts of the capital city Ulaanbaatar.

### **Rescue Operations on Findings from the Shuden Mountain**

Institute of History and Archeology of the Mongolian Science Academy and National Center for Cultural Heritage conducted joint rescue operations on artifacts discovered at the Shuden mountain of Davst soum, Uvs province in January 2018.

Scientists identified findings as remains of the body of the salt miner, who died in a landslide. From the radiocarbon analyses made in Japan, on the tooth from the remains, it was identified that remains belong to the Uigur empire period (767calAD-886calAD (89.3%)).

### **National Program on Intangible Cultural Heritage has been adopted**

By the Governmental Decree №68 of 13th of February, 2019, the "National Program on Safeguarding of the Intangible Cultural Heritage" has been adapted to be implemented in 2019-2023. For more details, refer to the article.

### **Research on Transmission and Loss of the Intangible Cultural Heritage in Eastern Regions of Mongolia**

In 2017, the research group consisting from independent researchers, professionals from the National Center for Cultural Heritage, researchers of the Khentii province museum, and officials from the Education, culture and arts department of the Dornod province conducted field-research in eastern region of the country, to identify the present situation of transmission of intangible cultural heritage elements by ethnical minorities in the region.

### **Risk Assessment of the Intangible Cultural Heritage**

In July 2017, the National Center for Cultural Heritage has signed a contract with the Swiss Agency for Development and Cooperation on implementation of the project "Mapping of the risk factors affecting the protection and safeguarding of cultural heritage in Mongolia". In the framework of the project, the negative factors affecting the cultural heritage elements and properties were identified, and presented as the "Cultural Heritage Risk Atlas".

### **Restoration and Consolidation of the Kherlen Bars Tower**

The work of the restoration and consolidation of the Kherlen Bars tower (X century) located in Tsagaan-Ovoo soum of the Dornod province was conducted in 2015-2016.

### **Rescue Works of the Shoroon Bumbagar Tomb Mural Paintings**

The center in cooperation with the Japanese restoration company "Sanshiki Sekkei", has organized rescue works on the mural paintings of the Shoroon Bumbagar tomb, located at the Bayannuur soum of the Bulgan province. As a result of rescue works, the mural paintings were documented and copied.

### **Restoration of findings from the grave at Uzuur Gyalan**

In April of 2016, a collaborative team of researchers from the Khovd University and Museum of Khovd province implemented archeological excavation works at the Uzuur Gyalan of the Munkhkhairkhan soum of the province. The objectives of the excavation works were to rescue findings from the grave discovered in the area. For more details, please refer to the article.

### **Restoration of Shuden Mountain Findings**

In December of 2017, during the salt mining, the mummy was found by the locals at the Shuden Mountain of the Uvs province. Thanks to the immediate report to the related officials and the findings were taken under the protection of the local government. Furthermore, by the decision of authorities, with the joint initiative of the Science Academy, Museum of the Uvs province and the National Center for Cultural Heritage the findings were preserved and consolidation and restoration works were conducted.

### **Use of the Trehalose solution on Organic Archeological Findings**

Many of the archeological findings from Mongolia are organic. And a big amount of those is made of wood. These findings need urgent innovative preservation methodology. Mongolian professionals have started to use preservation techniques tested by international experts. In particular, the Trehalose solution used by Japanese scientists is being used for the preservation of wooden artifacts.

## BRIEF IN ENGLISH

### **Restoration of the Ikh Burkhan Complex**

By the Governmental Decree №303 of 2007, Article 7.1.2. of the "National Program for Protection and Restoration of Immovable Historical and Cultural Monuments", №11 Order of the Prime Minister, the restoration works of the stone complex Ikh Burkhan was conducted at the Khalkh Gol soum of the Dornod province.

### **Completion of Documents for the Information and Registration Database of Historical and Cultural Moveable Heritage**

#### **(Guidance for employees of cultural centers)**

In this article, the expert of the Department for Cultural Heritage Registration and Research of the National Center for Cultural Heritage gives guidance and tips on completion of documents and other details for the Information and Registration Database of Historical and Cultural Moveable Heritage, according to the Law on Protection of Cultural Heritage and related legal acts.

### **About Documentary Heritage**

One of the unique heritage fields is the Documentary Heritage which contains elements of both intangible cultural heritage and tangible cultural heritage. Documentary heritage is transmitted and inherited in the form of written documents and audio & video recordings. The article provides information that gives understanding about the documentary heritage.

### **Capacity-Building Vocational Trainings on Protection and Safeguarding of Cultural Heritage**

The article introduces series of capacity-building training the National Center for Cultural Heritage has implemented in cooperation with such international organizations and institutions like the International Training Centre for Intangible Cultural Heritage in the Asia-Pacific Region (CRIHAP), Preservation and Protection Institute of the Austrian University of Applied Arts, American Center of Mongolian Studies, etc.




### **Implementation of the Project "Wonders of Mongolian Lock"**

In 2018 the National Center for Cultural Heritage in cooperation with the NGO "Council for Cultural Heritage Networking and Communication" and with financial support from the Fund for Development of Culture and Arts, has successfully implemented the project on research of Mongolian traditional lock intending to promote the heritage among the general public.

### **Flint Gun – the Forgotten Heritage**


"Flint Gun Making" is the intangible cultural heritage registered in the National List of Intangible Cultural Heritage in Need of Urgent Safeguarding of Mongolia, by order №84 of the Minister of Education, Culture, Science, and Sports, of 16th of March, 2011. The article introduces the heritage element and its history.

## СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВӨӨС 2014-2019 ОНД ХЭВЛЭГДЭН ГАРСАН НОМ, ЗОХИОЛУУД





2014



2019

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВӨӨС ЭРХЛЭН ГАРГАВ.

2014-2019/1 №8

Шуудангийн хаяг : Сүхбаатарын талбай 3, СБ дүүрэг Улаанбаатар 210620а, Монгол Улс

И-мэйл: info@ncch.gov.mn

Утас: 312735, 70110877

Факс: 976-11-312735

Веб сайт: [www.ncch.gov.mn](http://www.ncch.gov.mn)

Дугаарыг эрхэлсэн: Д.Нарантуяа

Эх бэлтгэл: П.Чинбат